

ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ: Баруун Австрали ба Күинсланд



2021 оны 7 дугаар сар
Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын
ажиллагааны хөтөлбөр

Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийг Австрали Улсын Гадаад харилцаа худалдааны яам санхүүжүүлэн, Адам смит Интернэйшнл компани хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЗОХИОГЧИД

Лей Кингдом, ШУ-ы Бакаларв(Геологи), MAusIMM

Лей нь эрдэс баялгийн салбарт 25 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд Баруун Австрали, Квинслэнд, Хойд Нутаг дэвсгэр, Өмнөд Австрали, Виктория мужуудад ажиллаж байсан. Тэрээр ашигт малтмалын төслийн эхний үе шат болон нөөц тодорхойлох, засгийн газар ба уламжлалт өмчлөлийн харилцаа, байгаль орчны зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн менежментийн чиглэлээр ажиллаж байсан. Лей нь эрдэс баялгийн төслийн эдийн засгийн үр ашигтай байдал, тэдгээрийн хөгжүүлэлтэд нөлөөлөх хүчин зүйлсийг стратегийн өнцгөөс авч үзэх, цогц үнэлгээ хийх өргөн хүрээний ажлын туршлагатай.

Рик Рожерсон, BSc(Hons), PhD, MBA, MAIG

Рик нь Папуа Шинэ Гвиней, Австралид техникийн болон бодлогын гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байсан бөгөөд Дэлхийн банк, AusAID, Гадаад харилцаа, худалдааны яамны гэрээгээр хөгжиж буй орнуудад ихэвчлэн эрдэс баялгийн бодлого, стратегийн менежментийн чиглэлээр техникийн туслалцаа үзүүлж ажилласан.

Тэрээр Австралийн Гео Шинжлэх Ухааны Судлалын Институтын Ерөнхийлөгч, Санхүү эрхэлсэн даргаар ажиллаж байсан.

Рик өмнө нь Баруун Австралийн Геологийн судалгааны газрын гүйцэтгэх захирал, Баруун Австралийн Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газрын нөөцийн ашиглалтыг хариуцсан гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан.

МЭДЭГДЭЛ

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэхүү хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

АГУУЛГА

Хууль тогтоомж ба үйл явц –хайгуулын тусгай зөвшөөрөл.....	5
Баруун Австрали – Күинсланд.....	5
Хайгуулын үйл ажиллагааны танилцуулга	10
Ил тод, тууштай ба тодорхой байдал	12
ХААНА ХАЙГУУЛ ХИЙХ ВЭ? ХАЙГУУЛЫН КОМПАНИУДЫН ХЭРЭГЛЭДЭГ	
ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦЫН ТОЙМ.....	14
Геологийн бололцоо ба хэтийн төлөв	14
Өмнөх хайгуулын ажлын үр дүн	14
Бодлогын төсөөлөл.....	15
Сонирхож буй газрын зөвшөөрлийг авах боломж.....	15
ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН БҮТЦИЙН ТОЙМ.....	16
Гол санаанууд	16
Засаглал	16
Хуулийн нөлөөллийн бүтэц	17
Эрх зүйн тогтоц.....	18
Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох механизм	19
Өргөдөл хянах, зөвшөөрөх процессын гол үе шатууд - тойм.....	19
Болзол Нөхцөл (эрх, зөвшөөрөл олгосны дараах).....	20
БАРУУН АВСТРАЛИ	23
Хууль эрх зүйн орчин	23
Эрлийн лиценз	25
Хайгуулын лиценз	26
КҮИНСЛАНД	32
Эрх, зөвшөөрөл авах өргөдөл гаргах эрх зүйн орчин.....	32
Хайгуулын зөвшөөрөл	32
Өргөдөл гаргах журам	33
Лицензийн болзол нөхцөл ба түүний нийцэл.....	40
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ	43
ХАВСРАЛТУУД.....	45

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хайгуулын зардал 2020.....	4
Зураг 2. Дэлхийн өнгөт металлын хайгуулын зардал.....	11
Зураг 3. Хөрөнгө оруулалтын таатай орчны индекс. Фрэйзэр, 2017 он.....	13
Зураг 4. Лиценз олгох процесс	21
Зураг 5. Байгууллагын бүтэц	22
Зураг 6. Эзэмшил бүхий газрын эрх авах өргөдлийн процесс	31
Зураг 7. Гендерийн үйл явц	40
Хүснэгт 1. Хайгуулын эрх олгох аргын харьцуулалт.....	6
Хүснэгт 2. Баруун Австрали ба Күинсландын гол хуулиуд.....	18
Хүснэгт 3. Эрэл хайгуулын болон хайгуулын лицензийн гол онцлогууд.....	27
Хүснэгт 4. Күинсландийн лиценз олгох механизм.....	32
Хүснэгт 5. Хайгуулын зөвшөөрлийн үндсэн өгөгдлүүд	33

Хууль тогтоомж ба үйл явц –хайгуулын тусгай зөвшөөрөл

Баруун Австрали – Квинсланд

Агуулга ба зорилго

Энэхүү тайланг Австралийн Засгийн газрын гадаад харилцаа, худалдааны яам (DFAT) -аас санхүүжүүлж, Адам Смит Интернэшнл хэрэгжүүлж буй Монгол Улсын Засгийн газар, Австралийн Засгийн газар хоорондын түншлэл болох Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр 2 (АМЕР 2)-ын хүрээнд бэлтгэн боловсруулав. АМЕР 2 хөтөлбөр нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын ирээдүйн өсөлтөд нэн чухал болох олборлох салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх зорилготой юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) нь хөрөнгө оруулалт татах, хайгуулын үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессийг сайжруулах судалгаа хийж өгөх хүсэлтийг АМЕР-т гаргасан.

Энэхүү тайлан нь Австралийн тэргүүлэх уул уурхайн муж болох Баруун Австрали ба Квинсланд мужуудын ашигт малтмалын (металл болон металл бус ашигт малтмал, нүүрс, барилгын материал) хайгуулын лиценз олгох тогтолцоог танилцуулах замаар Монгол Улсын УУХҮЯ-нд зөвлөмж өгөхийг зорьсон болно. Австрали улсад муж, нутаг дэвсгэрийн засгийн газар нь (нийт найм байдаг) өөрийн хил хязгаар доторх газар, эрдэс баялгийн нөөцийг удирдах эрхтэй бөгөөд, хайгуул, ашиглалттай холбоотой хууль гаргах эрхтэй. Мужийн засгийн газар нь ашигт малтмалыг олборлож гаргах хүртэл өмчлөх бөгөөд удирдлагын тогтолцоогоор хангадаг.

Австралийн муж улсын засгийн газрууд хайгуулын лицензээр тус мужийн эрдэс баялгийн мэдлэг ба гео шинжлэх ухааны мэдээллийг аривжуулах, улмаар ашигт малтмалын нөөц тогтоож илрүүлэхийн тулд идэвхтэй, үр дүнтэй хайгуул хийхийг хүсдэг. Лиценз авах шалгуур нь өндөр биш боловч лиценз эзэмшигчдэд тавигдах нөхцөл, шаардлагыг хатуу хянаж, "лицензийг ашиглах эсвэл алдах" зарчмын дагуу эзэмшүүлдэг. Лицензийг өгөгдсөн хугацаанд хийх жил бүрийн ажил болон хайгуулын ажлын зардлын доод хэмжээний үүргийг биелүүлсэн тохиолдолд л зөвхөн шинэчилнэ, мөн бүх лицензийн 'талбайг хадгалах' гэхээсээ илүү хайгуулын ажилд илүү төвлөрүүлэх зорилгоор дунд хугацаанд талбайн хэсгийг буцааснаар (хуулийн дагуу хэсэгчлэн буцаах үүрэг) хэмжээг нь бууруулж байдаг¹.

Австралид лиценз олгох тогтолцоо нь байгаль орчин, уугуул иргэдийн өвийг хамгаалах чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлсэнээс өөрөөр урт хугацаанд нэг их өөрчлөгдөөгүй байна. Австралид хайгуулын лицензийг "түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх" арга буюу өргөдөл гаргасан дарааллаар хууль, журамд тодорхой заасан процессийн дагуу олгодог.

Товч хураангуй ба гол дүгнэлтүүд

Баруун Австрали ба Квинсландын ашигт малтмалын хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн менежментийн тогтолцоо, ялангуяа хайгуул хийх эрх олгоход "түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх" арга нь олон талаар ижил төстэй.

Квинслэнд нь ашигт малтмалын ихэнх хайгуулын зөвшөөрөлд, Баруун Австрали нь ашигт малтмалын болон нүүрсний хайгуулын бүх лицензэд энэ аргыг ашигладаг. "Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх" аргаар лиценз олгох үйл явц нь хайгуулын ажлын төлөвлөгөө болон хайгуулын ажилд гаргах зардалд суурилсан сонгон шалгаруулалтаар эсвэл дуудлага

¹ Хайгуулын ажил маш бага хийгдсэн эсвэл огт хийгдээгүй, лицензийг өндөр үнээр өөр хайгууль эрхлэгчид шилжүүлэхийг хүсч байгаа лиценз эзэмшигчдийг хэлнэ.

худалдаагаар эрх олгох тогтолцооноос олон давуу талтай юм.

Хүснэгт 1-д Австрали дахь хайгуулын эрх олгох аргуудын давуу ба сул талыг нэгтгэн харуулав.

Австралийн Бүтээмжийн хороо²-ноос Австрали улсад 2013-14 онд хийгдсэн хайгуулын ажилд шилжилгээ хийж лиценз олгох гурван боломжит аргыг авч үзсэн. Энэхүү тайлангийн үр дүн нь Хэснэгт 1 дэх дүгнэлттэй нийцэж байгаа бөгөөд Австралийн өөр өөр мужуудын сонгон шалгаруулалт болон дуудлага худалдаанд суурилсан хайгуулын эрх олгосон жишээнүүд нь олгогдсон лицензийн тоо бага, захиргааны шийдвэр удаан, авлигын талаар гомдол гарсан, олгогдсон лиценз эзэмшигчийн хайгуулын гүйцэтгэл хангалтгүй байсан зэргээр хүссэн үр дүнд хүрээгүйг харуулсан.

Монгол улсын хувьд “түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх” аргаар лиценз олгох нь дараах давуу талуудтай байна. Үүнд:

1. Дотоодын компани, хувь хүмүүст хайгуулын эрхийн төлөө гадаад компаниудтай өрсөлдөх тэгш боломжийг олгоно. Сонгон шалгаруулалт эсвэл дуудлага худалдаанд суурилсан тогтолцоо нь гадаадын компани шиг техникийн мэдлэг, санхүүгийн эх үүсвэргүй Монголын өргөдөл гаргагчдын эсрэг хязгаарлалт буй болгоно.
2. Хайгуул хийхэд зориулсан геологийн нарийвчилсан үндэслэл ирүүлэх шаардлагагүй, харин лицензийн талбайд суурилсан хайгуулын төлөвлөгөө, зардлын доод хэмжээний санал ирүүлэх нь өргөдөл гаргагчдад хялбар байна.
3. Өргөдлийг ил тод шийдвэрлэж лиценз олгоход Засгийн газарт хялбар бөгөөд хурдан байх болно.
4. Лиценз эзэмшигч хайгуулын зардалын үүргээ биелүүлсэн, хайгуулын үйл ажиллагаа, зардал, байгаль орчны менежмент, гео-шинжлэх ухааны үр дүнгийн талаар гаргасан жилийн эсвэл хагас жилийн тайлан зэрэг хууль тогтоомжийн нийцэл нь засгийн газар хяналт тавьж, лицензийг цуцлах асуудлыг санаачлахад хялбар байх болно.

Хүснэгт 1. Хайгуулын эрх олгох аргын харьцуулалт

Аргууд	Давуу тал	Хайгуулын эрхтэй холбоотой асуудлыг авч үзэх нь
Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх	<p>Монголын компаниуд, хувь хүмүүст хайгуулын эрхийн төлөө гадаадын компаниудтай өрсөлдөх тэгш боломжийг олгоно.</p> <p>Компаниудын хувьд өргөдөл гаргах үйл явц хурдан бөгөөд хялбар болно.</p> <p>Санхүүгийн болон техникийн чадавхийг үнэлэх бодитой, ил тод шалгуурууд нь төрийн албан</p>	<p>Лиценз эзэмшигч нь зардлын доод хэмжээг биелүүлээгүй, үйл ажиллагаа, техникийн тайлан ирүүлээгүй, байгаль орчны стандартыг хангаагүй, лицензийн төлбөр төлөөгүй бол торгох /эсвэл лицензийг цуцлах арга хэмжээг хууль тогтоомжийн нийцлийн хатуу горимтой хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p>Өргөдөл гаргагч нь хайгуулын хөтөлбөр боловсруулах гео-шинжлэх ухааны үндэслэл гаргахад бага ач холбогдол</p>

² Хороо нь Австралийн засгийн газрын агентлаг бөгөөд Засгийн газрын зохиолгаар Австралийн эдийн засгийн үзүүлэлт, олон нийтийн сайн сайхан байдалтай холбоотой гол бодлого, зохицуулалтын асуудлаар олон нийтийн санал асуулга, судалгаа явуулдаг.

	<p>хаагчдын хувьд өргөдлийг шийдвэрлэхэд хялбар, хурдан болгоно.</p> <p>Лицензийн өргөдөлд заасан талбайд суурилсан зардалын доод хэмжээ нь нийцлийн хяналтыг хялбар, ил тод болгоно.</p>	<p>өгөх боломжтой</p>
<p>Ажлын төлөвлөгөө, зардалын үүрэгт суурилсан сонгон шалгаруулалт</p>	<p>Эхлээд цөөн тооны боловч илүү сайн эх үүсвэртэй лиценз эзэмшигч, мөн цөөн тооны лиценз олгогдож болзошгүй.</p> <p>Техникийн болон санхүүгийн хувьд "шилдэг" өргөдөл гаргагчидыг дэмжих замаар өргөн хүрээтэй бодлогын зорилт, үр дүнг дэмжинэ</p>	<p>Монголын компаниуд нь илүү сайн санхүүгийн эх үүсвэр, техникийн чадавхитай гадаадын өргөдөл гаргагчидтай өрсөлдөхөд харьцангуй давуу бус байдалтай болно.</p> <p>Засгийн газрын хувьд төлөвлөлт их шаардсан, зохион байгуулахад хугацаа уддаг, төрийн албан хаагчид болон шийдвэр гаргагчид нь нарийн шүүлт хийж шийдвэрлэх шаардлагатай болдог.</p> <p>Засгийн газрын үнэлгээчдээс хайгуулын гео шинжлэх ухаан, хайгуулын ажлын зардлын талаарх өндөр мэдлэг, техникийн ур чадвар шаардагддаг.</p> <p>Ил тод байдал бага, мөн зардлыг хөөрөгдөх боломж бий болгоно. Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх аргатай нэгэн адил хууль тогтоомжийн нийцлийн хатуу горим хэрэгжүүлэх шаардлагатай.</p>
<p>Бэлэн мөнгөөр худалдаалах тендер буюу дуудлага худалдаа</p>	<p>Засгийн газарт орлого шууд орно</p> <p>Хэтийн төлөв өндөртэй, гео шинжлэх ухааны сайн урьдач өгөгдөл, нөөцийн мэдээлэлтэй тохиолдолдолд оновчтой байж болно.</p>	<p>Монголын компаниуд нь илүү сайн санхүүгийн эх үүсвэр, техникийн чадавхитай гадаадын өргөдөл гаргагчидтай өрсөлдөхөд харьцангуй давуу бус байдалтай болох ба цөөн тооны санал ирж болзошгүй юм.</p> <p>Засгийн газрын хувьд төлөвлөлт их шаардсан, зохион байгуулахад хугацаа уддаг процесс юм.</p> <p>Шийдвэр гаргах үндэслэл нь тодорхойгүй, ил тод байдал багатай.</p> <p>Дуудлага худалдаанд илүү их мөнгө зарцуулах нь хайгуулын ажилд бага хөрөнгө оруулахад хүргэдэг.</p> <p>Авлигын эрсдэл, сэдэл бий болж болзошгүй.</p> <p>Өндөр чанартай гео шинжлэх ухааны урьдач өгөгдөл шаардлагатай.</p>

Дүгнэлт

Хайгуулын ажил нь санхүүгийн болон техникийн асар их эрсдэл дагуулдаг бөгөөд зээлээр бус компанийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөөр санхүүжүүлдэг. Нөөцийг тогтоож, урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулж эхэлсний дараа эрсдэл аажмаар буурдаг боловч хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, жижиглэн худалдааны үйл ажиллагаатай харьцуулахад өндөр хэвээр байна.

Австралийн хамгийн өндөр өрсөлдөх чадвартай уул уурхайн хоёр муж болох Баруун Австрали, Квинсландын ашигт малтмалын хайгуулын зохицуулалтын тогтолцоо, практикийн талаархи энэхүү судалгаагаар эдгээр мужуудын төдийгүй дэлхийн хэмжээний уул уурхайгаар тэргүүлдэг улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг шилдэг туршлагын зарчмуудыг тодорхойлсон болно.

Эдгээр шилдэг туршлагын зарчмуудад дараахь зүйлс орно. Үүнд:

1. Хайгуулын ажлын явцад гарах эрсдлийг бууруулах замаар хайгуулчид, хөрөнгө оруулагчдыг татах

Үүнд геологийн мэдээллийг (геологийн Зураглал, тайлан) онлайнгаар үнэгүй татаж авах, мөн уул уурхай, газрын тосны кадастрын үнэн зөв, хамгийн сүүлийн үеийн мэдээллийг онлайнгаар татаж авах боломжтой байх ёстой. Геологийн мэдээлэлд хууль тогтоомжид заасан нууцлалын хугацаа дууссаны дараа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн Засгийн газарт ирүүлсэн хайгуулын ажлын тайлан орно. Ашигт малтмалын кадастр нь доор тайлбарласан онлайн бүртгэлтэй холбогдсон байна. Ийм мэдээлэл нь одоо байгаа лиценз эзэмшигчидтэй хамтарч бизнес эрхлэхийг хүсч буй хайгуулчдын хувьд үнэлж баршгүй ач холбогдолтой бөгөөд лиценз нь засгийн газрын зүгээс баталгаатай олгогдсон байх хэрэгтэй.

2. Ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох талаарх тодорхой байдлыг салбарт бий болгох

Австралийн ашигт малтмалын тухай хууль тогтоомжид хайгуулын лиценз, зөвшөөрөл эзэмшигчид эрх, зөвшөөрлийн хүрээнд хамрагдах газарт тодорхой төрлийн эрх, зөвшөөрөл авах хүсэлт гаргах ба авах эрхтэй байхаар заасан байдаг. Хууль тогтоомжоор зохицуулсан эрхийн баталгаат бүртгэл нь энэхүү зарчмын үндэс суурь бөгөөд бүртгэлийн мэдээллийг газрын зурагт суурилсан ашигт малтмалын кадастрын онлайн системд оруулах нь зүйтэй. Эрхийн бүртгэлд лиценз тус бүрийн эзэмшигч, өргөдөл гаргасан, эрх олгосон, дуусгавар болох эсвэл буцаах огноо, талбайн солбицол, шилжилт хөдөлгөөний мэдээлэл багтана.

Австрали улсад ихэнх ашигт малтмалын хайгуулын эрхийг “түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх” зарчимаар хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг. Энэ нь хүчин төгөлдөр лицензэд хамаарахгүй, боломжит газарт шаардлага хангасан өргөдлийг түрүүлж гаргасан иргэн, компанид олгодог. Ашигт малтмалын салбарт энэ зарчим үйлчлэхгүй байх тохиолдол харьцангуй ховор байдаг. Газрын тосны хувьд болон зарим муж, нүүрсний хувьд өргөдөл гаргагчийн санал болгосон хайгуулын ажлын үндэслэл тооцоо, хайгуулын зардал дээр үндэслэн сонгон шалгаруулалтаар лицензийг олгодог.

Монгол Улсын нөхцөлд “түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх” тогтолцоог нэвтрүүлсэнээр Монголын компаниуд болон хувь хүмүүст хайгуулын эрх авахын төлөө гадаадын компаниудтай өрсөлдөх тэгш боломжтой болно. Сонгон шалгаруулалтын тогтолцоо нь гадаадын компаниудтай адил техникийн мэдлэг, санхүүгийн чадамжгүй дотоодын өргөдөл гаргагчдын хувьд давуу бус байдал үүсгэнэ.

Эрх олгох тогтолцоо нь лицензийн нэгж талбайд ногдох хайгуулын зардлын доод хэмжээг гаргах үүргийн шаардлагыг тогтоох замаар талбайг урт хугацаанд хадгалахын эсрэг хайгуулын идэвхитэй үйл ажиллагааг дэмжих шаардлагатай болдог.

3. Тодорхой, тууштай зохицуулалтын тогтоц ба удирдлагын тогтолцоог бүрдүүлэх

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардагдах, түүнчлэн олон нийт болон бусад оролцогч талуудад салбар нь эрх олгосон нөхцөл болзол, байгаль орчин, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үүргээ биелүүлж байгаа гэдэг итгэлийг бий болгоход салбар дахь тодорхой ба тууштай зохицуулалтын тогтоц зайлшгүй шаардлагатай. Австралийн бүх мужууд нь эрх, зөвшөөрөл олгоход холбогдох хууль тогтоомж ба, бодлогыг харгалзан шийдвэрлэдэг, эдгээр нь нэг төрлийн эрх, зөвшөөрлийн хувьд нэг мөр тууштай мөрдөгддөг явдалыг хангахын тулд чанарын процессын тогтолцоог хэрэгжүүлдэг.

Лиценз эзэмшигчид нь хууль тогтоомж болон эрх, зөвшөөрөл олгохтой холбоотой болзол нөхцлийг мөрдөх, нийцүүлэхэд онцгой анхаарал хандуулдаг бөгөөд зарим мужид лицензийн өргөдлийг шийдвэрлэх, нийцлийн үйл ажиллагааг хариуцах үүрэгтэй, тус бүрдээ гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт бүхий ахлах албан тушаалтануудын бүрэлдэхүүнтэй бүтэц бий болгосон байдаг. Энэ нь ялангуяа Австрал улсад ихэнх хайгуулын эрх, зөвшөөрлийн нийцэл нь хайгуулын ажилд зарцуулах зардлын доод хэмжээ, хийх ажлын үүрэг амлалт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хангуулахад суурилдаг тул онцгой ач холбогдолтой юм.

Баруун Австрали, Куинслэнд нь засгийн газрын хэмжээнд ил тод байдлыг дэмжиж, хайгуулын эрх, зөвшөөрөл түүний болзол нөхцөл, уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны жилийн тайлан зэрэг хайгуулын лиценз авах өргөдөл, үйл ажиллагаатай холбоотой олон төрлийн мэдээллийг вэбсайт дээрээ нийтэлдэг.

Хайгуулын үйл ажиллагааны танилцуулга

Монгол Улсын засгийн газар нь уул уурхайн салбарт шинээр хөрөнгө оруулалт татахын тулд эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн. Энэхүү зорилтод хүрч, ирээдүйд уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн тулд хайгуулын компаниудыг өөртөө татахаас эхэлнэ. Ашигт малтмалын хайгуул нь уул уурхайн салбарын чухал үндэс суурь бөгөөд хэрэв зардал, үйл ажиллагааны шаардлагыг албажуулан нэвтрүүлвэл шууд орлого, ажил эрхлэлтийг бий болгодог бас нэг салбар мөн.

Хөгжиж буй хайгуул, уул уурхайн салбарын үр өгөөжийг бүрэн хүртэхийн тулд ашигт малтмалын хайгуулын мөн чанарыг ойлгох нь чухал юм. Ашигт малтмалын хайгуулын ажил нь өөрөө өндөр эрсдэлтэй байдаг. Хайгуулын үйл явц нь шинжлэх ухааны хувьд нарийн төвөгтэй, хугацаа их шаарддаг, зардал өндөртэй бөгөөд хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нь хэдэн арван жилийн дараа л хүртэх магадлалтай. Колорадо дахь Уул уурхайн сургууль нь олон улсын өгөгдөл мэдээллийг ашиглан “500-1000 ширхэг шинэ хайгуулын төсөл хэрэгжүүлж байж л ахисан түвшний хайгуулын 100 талбай бий болгох магадлалтай бөгөөд эдгээрээс 10 төсөлийг цааш нь хөгжүүлэхэд зөвхөн нэг нь ашигтай уурхай болдог” гэж дүгнэжээ. Тиймээс, бодлогын өнцгөөс авч үзвэл, дийлэнх талбай нь хангалттай судлагдаагүй (‘ногоон талбай’) байгаа Монгол улсын хувьд аль болох олон тооны хайгуулын компани татах шаардлагатай болж байна.

Уламжлал ёсоор Австрали дахь орчин үеийн хайгуулын ихэнхийг дунд ба том уул уурхайн компаниуд (‘томууд’) хийдэг байсан. Энэ хандлага нь сүүлийн 40 жилийн хугацаанд өөрчлөгдөж, 2000 оноос хойш жижиг компаниуд (‘жижгүүд’) Австрали улсад хийсэн бүх хайгуулын ажлын 71% - ийн эзлэх болсон³. Үүнээс харахад жижиг компаниудыг нь ерөнхийдөө техникийн өндөр чадвартай гэж дүгнэж болох ба хөрөнгө оруулалт татах үйл ажиллагааны гол зорилт байх ёстой гэж дүгнэж болно.

1990-ээд оноос хойш томууд хайгуулын ажлын зардлын нэлээд хэсгийг уурхайн ойролцоо (‘хүрэн талбай’) хайгуулд төвлөрч ирсэн. Энэ төрлийн хайгуулын үйл ажиллагаа нь эрсдэл багатай бөгөөд бүтээгдэхүүний үнийн мөчлөгт бага өртөх хандлагатай байдаг.

Жижиг компаниуд нь уурхайг санхүүжүүлэх, хөгжүүлэх, ашиглах туршлагагүй байж болох ч энэ нь тийм ч их саад тотгор биш юм. Жижгүүд жижиг, дунд хэмжээний төслийг хэрэгжүүлж, нэмэлт хувьцаа гаргах, уурхайн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн тодорхой хэсгийг зээлэх замаар өөрийн хөрөнгийн баазаа өргөжүүлсэнээр шаардлагатай байгаа мэргэжлийн үйлчилгээг ихэвчлэн худалдаж авдаг. Эдгээр компаниуд томоохон нөөц илрүүлсэн тохиолдолд төслийг том компаниуд худалдан авч ашиглах, харин жижиг компани нь тодорхой хувь эзэмших хандлагатай байдаг. Эсрэгээр, хэрэв томоохон компани жижиг нөөц илрүүлсэн бол тухайн төсөл нь хэмжээ, ашигт ажиллагааны хувьд корпорацийн зорилтод нийцэхгүй байж болох юм. Тиймээс тэд төслөө жижиг эсвэл дунд хэмжээний компанид зарах магадлалтай.

Жижиг компаниудын хөрөнгө зарцуулалтын хэв шинж нь тогтворгүй, бас мөчлөгийн шинжтэй бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдээс хөрөнгө босгох чадвараас ихээхэн шалтгаалдаг нь Засгийн газрын хувьд сорилт болдог.

Зураг 1-т 2020 онд дэлхийн хэмжээнд хайгуулын салбарт нийт 8.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн ба Монгол Улс хайгуулын хөрөнгө оруулалт татахын төлөө өрсөлдөх хэрэгтэй гэдгийг энэ зураг харуулж байна.


³ <http://minexconsulting.com/the-current-state-of-play-for-exploration-in-australia>

Хайгуулын салбар нь улам бүр даяаршиж байгаа бөгөөд Зураг 2-т харуулсанчлан зарим хөгжиж буй бүс нутгуудад зардлын ихээхэн хэсэг нь ногдож байна. Гэхдээ геологи, эдийн засгийн асуудал нь ашигт малтмалын хайгуулын чухал хүчин зүйлүүд боловч бүс нутгийн бодлого, эрх зүйн тогтолцоо нь хөрөнгө оруулалтад мөн чухал үүрэг гүйцэтгэдэг.



Зураг 1. Хайгуулын зардал 2020

Эх сурвалж: S&P Global Market Intelligence, 2021. PDAC Special Edition: World Exploration Trends 2021. S&P Global, New York.



Зураг 2. Дэлхийн өнгөт металлын хайгуулын зардал

Эх сурвалж. Дэлхийн зах зээлийн тандалт судалгаа 2021. Нийт зардал 8,7 тэрбум ам доллар. Ашигт малтмалын үр өгөөж, улсын бодлого, татвар, хайгуулын эрх зүйн орчин зэрэгт үндэслэн

Канадын Фрейзерийн хүрээлэнгээс улс орнуудын хөрөнгө оруулалтын орчны таатай байдлыг эрэмбэлдэг жил бүрийн судалгаа нь улс орнууд хайгуулын салбараар өрсөлддөг гэдгийг харуулдаг. Хамгийн сүүлд 2017 оны Фрейзерийн хүрээлэнгийн судалгаанд Монгол Улс 91 орноос 53-т эрэмбэлэгдсэн (Зураг 3). Монгол Улсын рейтинг, 2016 онд 101 (104-с)-с 70 (91-с) болон сайжирч, 2017 онд 26 нэгжээр нэмэгдсэн хэдий ч геологийн өгөгдөл мэдээлэл (-39 оноо), хүний нөөцийн хүртээмж ба ур чадвар (-32 оноо), тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой байдал (-27 оноо) зэрэг асуудлаар оролцогсодын өгсөн хариултаар эрэмбэ нь буурсан.

2017 онд Австралийн хамгийн өндөр эрэмбэтэй мужууд болох Баруун Австрали, Квинсланд нь 5, 12-т тус тус жагссан бол 2020 оны судалгаагаар Баруун Австрали Дэлхийд 4-т бичигджээ.

Монгол Улсад хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процесс, тогтолцооны сонголт, хувилбаруудыг авч үзэхийн тулд энэхүү тайланд Баруун Австрали ба Квинсланд зэрэг Австралийн хоёр мужийн хайгуулын лиценз олгох тогтолцоог тоймлон харуулав. Эдгээр мужуудыг Австралийн уул уурхайн салбартаа тэргүүлэгч муж болохын хувьд сонгож авсан бөгөөд Баруун Австрали нь Фрейзерийн Институтээс жил бүр явуулдаг дэлхийн уул уурхайн судалгааны Хөрөнгө оруулалтын таатай орчны индекс, хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ дэлхийд тогтмол эхний 5-д ордог⁴.


Австралийн мужийн засгийн газрууд хайгуулд хөрөнгө оруулалт татахуйц бодлого, эрх зүйн тогтолцоогоор хоорондоо өрсөлддөг. Баруун Австрали ба Квинсландын аль алинд нь хайгуулын лиценз хүссэн өргөдөлийг үнэлэх ба шийдвэрлэхэд дараах үндсэн зарчмуудыг баримталдаг:

Ил тод, тууштай ба тодорхой байдал

- Процесс, цаг хугацаа (өөрөөр хэлбэл шийдвэр гаргах хугацаа) ба хамрах хүрээ (холбогдох шалгуур үзүүлэлтүүд) –ны тодорхой байдал:
 - Хууль
 - Журам
 - Бодлого, зааварын хэрэгжилтийн тууштай байдал.
- Бүх оролцогч талуудад мэдээлэгдсэн тодорхой тогтолцоо, үйл явц (бодлого, заавар)
- Шийдвэр гаргалтын ил тод байдал, жишээлбэл, хатуу чанд эсвэл хангалттай нийцэл
- Олж авахад хялбар, сайн чанарын газарзүйн шинжлэх ухааны мэдээлэл
- Лиценз эзэмшигчдэд эрэл хайгуулыг эрчимтэй, чанартай хийх, гео-шинжлэх ухааны мэдээллийг засгийн газар болон бусад хайгуулчдад тайлагнах үүрэг хүлээлгэх

Ил тод байдал нь төр, хөрөнгө оруулагчдын аль алиных нь хувьд хууль тогтоомжийн хэрэгцээгүй тодорхой бус байдлыг багасгаж, бүх лиценз эзэмшигчид хууль тогтоомжид тодорхой заасан дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулах ижил нөхцлийг хангана.

⁴ <https://www.fraserinstitute.org/studies/annual-survey-of-mining-companies-2020>.



Зураг 3. Хөрөнгө оруулалтын таатай орчны индекс. Фрэйзер, 2017 он.

Эх сурвалж: Стеман, А., Грийн, К., 2018. *Фрэйзерийн хүрээлэнгээс жил бүр явуулдаг уул уурхайн компаниудын судалгаа* 2017 он. Фрэйзерийн хүрээлэн, Ванковер.

ХААНА ХАЙГУУЛ ХИЙХ ВЭ? ХАЙГУУЛЫН КОМПАНИУДЫН ХЭРЭГЛЭДЭГ ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦЫН ТОЙМ

Хайгуулыг эрчимжүүлж, дэмжихийн тулд төрийн байгууллагууд хайгуулын компаниудын хэрэглэдэг шийдвэр гаргах үйл явцыг авч үзэх шаардлагатай. Хаана хайгуул хийхээ шийдэхийн тулд компаниуд гурван үе шаттайтайгаар дараах хүчин зүйлсийг үнэлдэг. Үүнд:

- Геологийн потенциал ба хэтийн төлөв, түүний дотор зорилт (өөрөөр хэлбэл ашигт малтмалын орд) тодорхойлох хялбар ба магадлалтай байдал.
- 'Бодлогын ойлгомжтой байдал', өөрөөр хэлбэл, хууль тогтоомж (уул уурхай, байгаль орчин, татвар г.м.) болон эрхийн баталгааны тодорхойгүй байдал.
- Сонирхож буй талбайг авах боломж, түүний дотор хүчин төгөлдөр эрх, зөвшөөрөл⁵, тэдгээрийн эзэмшигчид болон дуусгавар болох хугацаа, лиценз авах өргөдөл гаргах процессийн талаарх мэдээлэл.

Геологийн бололцоо ба хэтийн төлөв

Үүнд эдийн засгийн үр ашигтай хүдрийн биет агуулсан талбайн потенциалыг үнэлэх явдал орно. Ихэнх компаниуд өөрсдийн геологийн загвараар эрдэсийн потенциалыг үнэлэх ба дараахь нарийвчилсан мэдээлэл шаардагддаг. Үүнд:

- Эрдэсийн тогтоогдсон хуримтлалууд (тэдгээрийн хэмжээ), тэдгээрийн байршил, шинж чанар,
- Дараах дэлгэрэнгүй мэдээлэл (хэрэв байвал):
 - Геологийн зураг (чулуулгийн насжилт ба төрөл)
 - Тогтоцын зураглал
 - Геофизикийн өгөгдөл (дижитал хэлбэрээр)
 - Геохимийн өгөгдөл (дижитал хэлбэрээр)

Өмнөх хайгуулын ажлын үр дүн

Өмнө хийгдсэн хайгуулын ажлын хэр хэмжээ болон хэр эрчимтэй хайж, өрөмдсөн байдалд үнэлгээ хийнэ. Үүний тулд компани нь дараахь зүйлийг авч үзнэ.

- Хийгдсэн ажлын хэмжээ, төрөл. Энэ нь геологийн загварын тухай болон тохиромжгүй геологийн загварыг ашиглан буруу газарт төвлөрсөн эсэх талаархи мэдээллийг өгдөг; шинэ өгөгдөл мэдээлэл олж авах, мөн технологи өөрчлөгдөхийн хэрээр геологийн загвар нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг.
- Өмнөх хайгуулын ажлын үр дүн.
- Өрөмдсөн цооногуудын байршил, гүн, түүний дотор өрөмдлөгийн бүртгэл, шинжилгээний мэдээлэл (геологийн тогтоц, эрдсийг тодорхойлох зорилгоор хийгдсэн).

Ихэнх барууны хайгуулын багууд (томоохон болон жижиг компаниудын аль аль нь) геологийн

⁵ Зөвшөөрөл гэдэг нь эрэл, хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт зэрэг бүх төрлийн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хамарсан ерөнхий нэр томъёо юм.

судалгаа эсвэл өмнөх хайгуулаар хийсэн геофизикийн, геохимийн болон тогтоцын зурагийн өгөгдөл мэдээлэлд өөрсдөө тайлал хийхийг илүүд үздэг.

Хайгуулын технологийн үр өгөөж ба зардал нь орд нээх зорилтын магадлал ба хялбар байдлыг нөхцөлдүүлдэг нэмэлт хүчин зүйл болох бөгөөд энэ нь ялангуяа газрын гүнд хийх хайгуулд илүү хамаарна(Австрали улсад ихээхэн асуудалтай). Том хэмжээтэй, харьцангуй гадаргууд ойрхон, эрдэсжилт нь ил ашигт малтмалын ордыг илрүүлэх нь 200 метрийн гүнд байрлах жижиг хэмжээний орд илрүүлэхэс илүү хялбар байдаг.

Бодлогын төсөөлөл

Хөрөнгө оруулалт хаана хийх талаар шийдвэр гаргахад геологийн хэтийн төлөв чухал ач холбогдолтой боловч хайгуулын компани нь ашигт малтмалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой (эсвэл тодорхой бус) байдлыг эрсдэлийн үнэлгээ хийх замаар авч үздэг. Үнэлгээний баг нь дараахь хүчин зүйлсийг үндэслэн үнэлгээ хийнэ. Үүнд:

- Ордын хэмжээ ба чанар; байршлын гүн (зардал ихсэх үр дагавартай).
- Дэд бүтэц (эрчим хүч, ус, зам г.м).
- Татвар, хөрөнгө оруулалтын дэглэм, үүнд ашгаа гадагш гаргах боломж, худалдааны саад тотгор орно.
- Нийгэм, эдийн засаг ба орон нутгийг хөгжүүлэх болзол нөхцөл.
- Хувь хүний аюулгүй байдал.
- Эрхийн баталгаа.
- Улс төрийн тогтвортой байдал ба авлига, бизнесийн эрсдлийн ойлголт.

Сонирхож буй газрын зөвшөөрлийг авах боломж

Компани нь эхний ээлжинд тухайн талбай түүний орчим байгаа хүчин төгөлдөр эрх, зөвшөөрлийн талаар үнэн бодит, хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, түүний дотор эрх зөвшөөрөл эзэмшигч болон эрх, зөвшөөрөлийн дуусах хугацаа, буцаах талбай тухай мэдээлэл авахыг хүснэ. Түүнчлэн, компанийн өрсөлдөх чадвараа хадгалах, "дундаж үзүүлэлтээс дээгүүр" ажиллах хүсэл сонирхолтой холбоотой нууцлалын асуудал байж болно. Иймээс нийтэд нээлттэй геологийн судалгааны мэдээллийг авахдаа нэрээ нууцлах, өргөдлийг онлайнгаар гаргах боломжтой байх нь маш чухал юм.

ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН БҮТЦИЙН ТОЙМ

Гол санаанууд

- Австралийн бүх хайгуул, олборлолтыг хувь хүмүүс эсвэл компаниуд гүйцэтгэдэг - Австралийн засгийн газар хайгуулын болон ашиглалтын компани эсвэл төсөлд хувь эзэмшдэггүй.
- Австралийн Үндсэн хуульд ашигт малтмал, газрын талаар тусгайлан заагаагүй; ашигт малтмал ба газрын асуудлыг мужууд удирддаг.
- Ашигт малтмал нь лиценз эзэмшигч түүнийг олборлож гаргах хүртэл муж улсын өмчлөлд байна.
- Компани эсвэл хувь хүн ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах онцгой эрх авахын тулд тухайн мужийн ашигт малтмалын хууль тогтоомжийн дагуу өргөдөл гаргана. Муж бүр ашигт малтмалын хайгуул, ашиглалтыг зохицуулах эрх зүйн горимыг тогтоодог.
- Канад, Австралид газрыг олон зорилгоор ашиглах үзэл баримтлал үйлчилдэг. Энэ нь ихэнх газрыг хайгуул, олборлолт хийхээр түр ашигладаг бөгөөд газрын зарим хэсгийг өөр зорилгоор ашиглах боломжыг давхар олгодог бөгөөд хайгуул, олборлолт дууссаны дараа энэ нь хэрэгжих боломжтой.
- Газрыг "ашиглах эсвэл алдах" зарчим нь лиценз эзэмшигч тухайн газарт ашигт малтмал эрчимтэй хайхгүй, эсвэл олборлохгүй бол Засгийн газар лицензийг цуцална гэсэн үг юм. Энэ нь 'газрыг урт хугацаанд хадгалах' явдлаас сэргийлдэг.

Засаглал

Австралийн ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг Австралийн үндсэн хуулийн тогтолцоо, Холбооны болон муж улсын засгийн газрын эрх мэдлийг авч үзэхгүйгээр ойлгох боломжгүй. Ашигт малтмал, түүний олборлолтын талаар хууль тогтоох эрх мэдэл нь Холбооны улсад бус муж улсуудад хамаарна. Гэвч Холбооны улс нь олон улсын худалдаа (экспорт, импорт), татвар, иргэний харьяалал гэх зэрэг хууль гаргах эрх мэдэлтэй. Эх газар дээрх ашигт малтмалын хувьд муж тус бүр өөрийн гэсэн хууль тогтоомжтой байдаг.

Ашигт малтмал, эрчим хүчний баялгийг муж улсууд өмчилдөг боловч Австралийн иргэд шууд бус хэлбэрээр өмчилдөг. Муж улсын засгийн газар нь улсын эрдэс баялаг, эрчим хүчний баялгийг Австралийн хүн амд үр өгөөжтэй байдлаар удирдан зохион байгуулах үүрэгтэй.

Австралийн болон муж улсуудын засгийн газрууд Австралийн Гео Шинжлэх ухааны газар болон муж тус бүрийн геологийн албадаар дамжуулан өөр өөрсдийн мэдээллээ цуглуулдаг (гео шинжлэх ухааны мэдээлэл). Засгийн газар нь ашигт малтмалыг үр дүнтэй ашиглах ба удирдах болон газар ашиглагчдын хооронд үүсч болзошгүй зөрчлийг зохицуулах асуудлаар мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахын тулд ашигт малтмалын байршил, шинж чанарын талаархи мэдээллийг шаарддаг. Муж бүр хэзээ, хаана ямар үндэслэлээр хайгуул хийж болохыг тусгасан хууль эрх зүйн тогтоцыг бий болгосон байдаг.

Хайгуулын лиценз нь хайгуулын компаниудад ашигт малтмалын эсвэл эрчим хүчний (нүүрс, уран) орд (ихэвчлэн газрын хэвлий дэх) хайж илрүүлэх онцгой эрхийг олгодог. Хайгуул нь ихэвчлэн газар тариалан эрхэлж буй газар, нутгийн уугуул иргэдийн өв, байгаль орчны талаар онцгой ач

холбогдолтой газар зэрэг өөр хэрэглээ ба зориулалттай газар дээр явагддаг. Газрын өөр өөр зорилготой хэрэглээний асуудал болон маргааныг шийдвэрлэхийн тулд олон янзын журам, бодлого ба дүрэм боловсруулсан байдаг.

Засгийн газрын зохион байгуулалтын бүтэц

Австралийн бүх муж улсад ашигт малтмалын хайгуул, ашиглалтыг удирдах, хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллагуудтай. Ихэнх засгийн газрын ашигт малтмалыг хариуцсан албадуудын үүрэг хариуцлага нь нь ашигт малтмалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч, геологийн судалгаа хэрэгжүүлэгч ба бодлого боловсруулагч нарт хуваарилан зохион байгуулсан байдаг.

Хэрэгжүүлэгч чиг үүрэгтэй байгууллага нь эрх, зөвшөөрөл олгох, байгаль орчны нөлөөлөл, уул уурхайн аюулгүй байдлыг хариуцдаг. Геологийн алба нь нийтэд нээлттэй болгох техникийн болон геологийн мэдээллийг цуглуулах, удирдан зохион байгуулах үүрэгтэй. Тухайн талбайн хэтийн төлөвийг үнэлэхийн тулд эхний шатанд нийтэд нээлттэй геологийн мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг учир хөрөнгө оруулалт татах, хайгуулыг хөхүүлэн дэмжихэд геологийн алба чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хуулийн нөлөөллийн бүтэц

Австрали улсын ашигт малтмалын тухай хууль нь хоорондоо холбоотой гурван хэсгээс бүрдэх ба гурвууланг шүүхэд авч үзэн хэрэглэнэ; Үүнд хууль, журам, бодлого ба заавар орно. Хууль, журам, бодлого ба заавар нь ашигт малтмалын хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тус тусдаа биш гурвуулаа шаардагдана.

Юу Хууль (Акт)

Хэрхэн Журам

Хэзээ/Хэрэв Бодлого ба заавар (хууль, журмыг хэрэгжүүлэхэд туслах, шийдвэр гаргалтыг зааварчлах)

Хуулийг Парламент батлах ба энэ нь хууль хэрэгжүүлэхэд нөлөөлөх бүх зүйлийг тусгасан эрх зүйн хэм хэмжээ юм. Хууль нь 'юу' гэдгийг тодорхойлно. Жишээлбэл:

- Тухайн муж улсад явуулах хайгуул, ашиглалтын төрөл (жишээлбэл, ашигт малтмал, газрын тос, газрын гүний дулаан гэх мэт)
- Зөвшөөрлийн төрөл, түүний болзол нөхцөл (техникийн болон зардалын тайлан, төлбөр гэх мэт), өргөдөл шийдвэрлэх, талбай буцаах процесс, нөхцөл гэх мэт.
- Хууль тогтоомж үйлчлэх ашигт малтмал, тэдгээрийн тодорхойлолт.
- Газар ашиглалт (жишээлбэл, хувийн газарт үйл ажиллагааг тогтоосон гүнд явуулна).

Түүнчлэн хуульд "хийж болох" ба "хийвэл зохих" зүйлсээс "хийсэн байх" эсвэл "хийх ёстой" зүйлийг ялгаж зааж өгсөн байна. "Хийсэн" эсвэл "хийх ёстой" гэж заасан тохиолдолд ямар ч журам, бодлого, эсвэл албан тушаалтан хуулийн шаардлагыг давах, зөрчих эрхгүй – харин "хийж болно" гэж заасан тохиолдолд журам, бодлогоор уян хатан зохицуулах боломжтой.

Журам нь хуулийг хэрхэн яаж хэрэгжүүлэхийг харьцангуй зааварласан баримт бичиг юм. Жишээлбэл, хуулиар хайгуулын лиценз олгохыг зөвшөөрсөн байдаг бол журам нь эрх, зөвшөөрөл авахын тулд өргөдөл заавал гаргах ёстойг, мөн урьдчилж тогтоосон шаардлагыг хангасан байх ёстойг "зааварчилсан байдлаар" тогтооно.

Эцэст нь, хэрэв хууль ба журамд тодорхой асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгаагүй бол, жишээлбэл өргөдлийг хэрхэн хянах нь тодорхойгүй бол хууль хэрэгжүүлэгч байгууллагын

бодлогын баримт бичиг, заавар, дүрмийг батлуулж мөрдөнө. Энэ нь өргөдлийг хянах ба шийдвэр гаргах үйл явцыг тууштай ба тогтвортой болгодог. Бодлого, заавар нь нийтэд нээлттэй байна. Бодлого, зааварыг парламентаар хянуулах шаардлагагүй тул байнга шинэчлэн, сайжруулах боломжтой, гэхдээ бодлогыг шинэчилсэн тохиолдолд өмнөх бодлогын дагуу ирүүлсэн өргөдлийг хэрхэн шийдвэрлэхийг нарийвчлан тогтоох шаардлагатай (ихэвчлэн өмнөх зааврын дагуу шийдвэрлэдэг).

Эрх зүйн тогтоц

Австрали Улс нь дэлхийд анхны гэж тооцогдох уул уурхайн тухай хуулийг 1852 оны Викториягийн Уурхайн Акт нэрээр баталсан тул ихээхэн хүндэтгэл хүлээдэг бөгөөд үүний үр дүнд Австралийн уул уурхайн тухай бүх хууль нь нийтлэг үндэс суурьтай. Гэвч цаг хугацааны эрхээр ашигт малтмал, эрчим хүчний баялгийн зохицуулалт нь илүү нарийн төвөгтэй болсон бөгөөд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан компаниуд нь Холбооны болон муж улсын хорь гаруй хууль тогтоомжийг дагаж мөрдөх шаардлагатай болжээ.

Ерөнхийдөө хайгуулын ажилд хамаарах хууль тогтоомж нь баялгийн төрлөөр (ашигт малтмал, газрын тос гэх мэт) болон үйл ажиллагаа нь эх газар дээр эсвэл далайд явагддаг эсэхээс хамааран өөр өөр байдаг. Ихэнх мужийн уул уурхайн хууль тогтоомж нь дор хаяж дөрвөн хууль ба дагалдах журмаас бүрддэг. Баруун Австрали ба Квинсландын гол хуулиудыг э Хүснэгт 2-т жагсаав.

Хүснэгт 2. Баруун Австрали ба Квинсландын гол хуулиуд

Муж	Эх газар	Эх газар	Далай	Далай
	Ашигт малтмал	Газрын тос	Ашигт малтмал	Газрын тос
Квинслэнд	Ашигт малтмалын тухай хууль 1989 ⁶	Газрын тосны тухай хууль 1923 Газрын тос, байгалийн хий (үйлдвэрлэл ба аюулгүй байдал) тухай	Оффшор ашигт малтмалын тухай хууль 1998	Газрын тосны (Усан доорхи) тухай хууль 1982
Баруун Австрали	Уул уурхайн хууль 1978	Газрын тос, газрын гүний дулааны энергийн тухай хууль 1967	Оффшор ашигт малтмалын тухай хууль 2003	Газрын тос, усан доорхи газрын тухай хууль 1982

Австралийн зарим мужуудад нүүрс зэрэг ашигт малтмалын төрөл, газрын гүний дулааны эрчим хүчний хайгуул зэрэг тодорхой үйл ажиллагаанд хамаарах нэмэлт хууль тогтоомжтой байдаг. Ашигт малтмалын төрөл, үйл ажиллагааны тухай тусдаа хууль тогтоомж нь зөвшөөрөлтэй талбайн давхцалыг зохицуулахад хэрэг болдог (жишээлбэл, газрын тос, ашигт малтмалын болзошгүй нөөцтэй талбайд ашигт малтмалын болон газрын тосны хайгуулын зөвшөөрөл давхцуулан олгогдсон байж болно).

⁶ Австралийн хуулиудын нэрсийн дараа анх батлагдсан огноо бичигддэг хэдий ч нэмэлт өөрчлөлтүүд орсон хувилбар байдаг.

Баруун Австрали ба Квинсландад ашигт малтмал, нүүрсний хайгуулын ажлыг парламентаас баталсан нэг хуулиар зохицуулдаг.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох механизм

Австралид ашигт малтмалын хайгуул хийх эрх нь үндсэндээ тухайн мужийн засгийн газрын төлөө, түүний нэрийн өмнөөс ашигт малтмалын орд илрүүлэх гэрээ гэсэн үг юм. Хайгуулын лиценз нь 'хөрөнгийн эрх' (газрын шууд өмчлөлөөс ялгаатай) бөгөөд засгийн газрууд нь нээгдсэн ордыг хэн олборлох эрхтэй болохыг тодорхойлдог тодорхой үндэслэл бүхий хайгуулын лиценз олгох процесстэй.

Хайгуулын лиценз олгох үндсэн гурван арга бий. Үүнд:

- Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх, ө.х. өргөдлийн процесс.
- Ажлын төлөвлөгөө, зардалд үндэслэсэн сонгон шалгаруулалт.
- Дуудлага худалдаа (оффшор газрын тосны, Холбооны улсын усны, Квинсландын нүүрсний сонгон шалгаруулалт; хамгийн бага ашиглагддаг). Лиценз олгох механизм нь ямар байхаас үл хамааран муж тус бүр өргөдөл гаргагчаас лиценз авах өргөдөл гаргахдаа хайгуулын ажлын төлөвлөгөөгөө ирүүлэхийг шаарддаг. Ажлын төлөвлөгөө нь хайгуулын үйл ажиллагааний үед байгаль орчин, уугуул иргэдийн өв соёл, газар ашиглах үүргийн нийцэлээ хангаж ажиллах боломжийг олгодог.

Өргөдөл хянах, зөвшөөрөх процессын гол үе шатууд - тойм

Австралийн муж тус бүр нь хайгуулын зөвшөөрөл олгох өөр өөр зохицуулалттай хэдий ч эдгээр нь олон талаараа хоорондоо ижил төстэй. Зураг 4-т хайгуулын лиценз олгох процессийн үндсэн үе шатуудыг тодорхойлсон болно.

Баруун Австрали, Квинсландын аль алинд нь хайгуулын лиценз хүссэн өргөдлийн 80 гаруй хувийг өргөдөл гаргагчид яамны лицензийн бүртгэлийн мэдээллийн сангийн өгөгдлөөс урьдчилж бөглөсөн өргөдлийн маягтэд мэдээллээ нэмж оруулан онлайн аар ирүүлдэг. Эдгээр маягтууд нь ухаалаг бөгөөд өргөдлийн маягтийг үнэн зөв бөглөх, яамнаас шаардсан бүх мэдээллийг оруулах нөхцлийг хангадаг.

Цаасан хэлбэрээр ирүүлсэн өргөдөлд ирүүлсэн огноо, цагийг дардасаар тэмдэглэж, яамны лицензийн бүртгэлийн мэдээллийн санд сканнердаж оруулна.

Өргөдлийг хянан шийдвэрлэх үйл явц практикт дараах байдлаар явагдана, лицензийн бүртгэл хариуцсан яамны ажилтан ирүүлсэн өргөдлийг системээс татан авч, өргөдөл гаргагчийн хайгуулын ажилд зарцуулах зардлын доод хэмжээг санхүүжүүлэх чадавхи, төлөвлөгөөнд тусгасан хайгуулын ажлыг гүйцэтгэх техникийн чадавхийг үнэлнэ. Зарим мужуудад хайгуул хийх шалтгаан үндэслэлд үнэлгээ нэмж хийдэг.

Бүртгэл хариуцсан ажилтанууд дор дурдсан бусад үнэлгээ хийх, эсвэл үйл ажиллагаа явуулж болно.

Үүнд:

- өргөдөл нь байгаль хамгаалах газар нутаг (энэ тохиолдолд Байгаль орчны сайд оролцоно) эсвэл бусад нөөц газартай хэр хэмжээнд давхацсаныг

- өргөдөл нь хувийн эзэмшлийн газарт (өөрөөр хэлбэл засгийн газрын биш газарт) хэр хэмжээнд нөлөөлөхийг
- өргөдлийг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад илгээх
- өргөдөлтэй холбоотой аливаа татгалзах саналуудыг авч үзэн шийдвэрлэх

Австралийн мужуудад ашигладаг онлайн өргөдлийн систем нь өргөдлийг хянаж үнэлдэггүй- энэ нь өргөдөл гаргагчаас хүчинтэй өргөдөл гаргахад шаардлагатай бүх мэдээллийг хүлээж авахад, өргөдлийг хадгалах найдвартай мэдүүлгийн системийн үүрэг гүйцэтгэхэд, дээд шатны албан тушаалтанаас дотоод зөвшөөрөл авахын тулд бүртгэл хариуцсан ажилтанаас дижитал хэлбэрээр шилжүүлэхэд ашигладаг систем юм.

Бүртгэл хариуцсан ажилтанууд нь ихэнхдээ техникийн бус, хууль эрх зүйн мэргэжилгүй захиргааны ажилтнууд байдаг ба цөөн хэдэн ахлах ажилтнууд хуульч эсвэл хагас хуульч мэргэжилтэй байдаг. Баруун Австралийн хувьд өргөдлийг шийдвэрлэхэд геологчид оролцдоггүй.

Үндсэн шаардлага – өргөдөл гаргах


- Санхүүгийн чадавхи (төлөвлөгөөнд тусгасан ажлыг гүйцэтгэх)
- Техникийн чадавхи
- Хүний нөөцийн шаардлага “тохирсон зөв хүн” (удирдлага, удирдах зөвлөлийн гишүүд гэх мэт).
- Төлөвлөж буй хайгуулын ажлын геологийн найдвартай үндэслэл (зарим муж, Баруун Австралид үүнийг шаарддаггүй)

Болзол Нөхцөл (эрх, зөвшөөрөл олгосны дараах)

Тайлагнах

- Жилийн:
 - Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
 - Зардал
 - Техникийн – геологийн өгөгдөл мэдээлэл (Геологийн албанд хүргүүлдэг)
- Хуулийн дагуу буцаасан, өөрөө буцаасан талбай, эцсийн тайлан.

Жилийн үйл ажиллагаа болон техникийн тайлан нь хайгуулд төлөвлөсөн зардалыг гаргасаны нотолгоог бүрдүүлнэ гэдгийг онцлох нь чухал юм. Жишээлбэл, лиценз эзэмшигч нь зардалын тайланд өрөмдлөг хийхэд 100,000 ам.доллар гэж тайлагнасан бол үйл ажиллагааны тайланд цохилтот өрмөөр 300 метрийн өрөмдлөг хийсэн гэж тайлагнана, мөн үйл ажиллагааны тайланд геохимийн шинжилгээ хийсэн гэсэн бол зардалын тайланд шинжилгээнд зарцуулсан хөрөнгийг тусгасан байх ёстой. Харин техникийн тайланд өрөмдлөгийн бүртгэл, геохимийн шинжилгээний үр дүнг тусгасан байх ёстой.



1. Ажлын төлөвлөгөөг өргөдөлтэй хамт ирүүлэх ёстой боловч шийдвэр гаргахад авч үзэхгүй.
2. Муж улсууд байгаль орчин, соёлын өв болон газарт нэвтрэх өөр өөр гэрээг лиценз олгох процессийн өөр өөр үе шатуудад шаарддаг.

Зураг 4. Лиценз олгох процесс

Эх сурвалж: Mineral and Energy Resource Exploration, Productivity Commission Inquiry Report, No. 65, 27 September 2013.

Үүрэг

- 'Ашигла эсвэл алд' –лицензийг хугацааг сунгахын тулд өгөгдсөн хугацаанд ажлын төлөвлөгөөний үр дүн / зардалын шаардлагыг хангасан байх (Баруун Австрали).
- Болзол нөхцөл шаардлагад өөрчлөлт оруулах / чөлөөлөгдөх хүсэлтийг урьдчилж ирүүлсэн байх (хэрэв шаардлагатай бол).
- Жилийн төлбөр, бусад төлбөрийг хугацаанд нь төлөх.

Сунгалт

- Хууль тогтоомжийн нийцлийг харуулсан байх.
- Лицензийн хугацаа хязгаартай (ж.нь. хамгийн дээд тал нь 15 жилээр олгох, 5 жилээр гурван удаа сунгана.) Дээд хязгаараас цааш зөвхөн онцгой нөхцөлд сунгана.

Лицензийг олгосноос хойших хууль тогтоомжийн биелэлт

Лицензийг анхлан ямар аргаар ("түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх эсвэл сонгон шалгаруулалт) олгосноос үл хамааран "ашиглах эсвэл алдах" болзол нөхцөл нь дээр дурдсан дагуу лиценз эзэмшигч нь лицензтэй холбоотой болон бусад холбогдох хууль (жишээлбэл, байгаль орчны хууль тогтоомж), журам, заавар, лицензийн болзол нөхцлийг биелүүлэн ажиллаж байгааг Засгийн газраас тодорхойлох суурь нөхцөл болгож тайлагнахыг шаарддаг. Австралийн муж улсуудад лиценз эзэмшигч тайлан ирүүлэхгүй байх, холбогдох хууль тогтоомжуудыг дагаж мөрдөхгүй байх нь торгууль ногдуулах / эсвэл лицензийг нь цуцлах үндэслэл болдог. Үүнд байгаль орчны тухай хуулийг дагаж мөрдөхгүй байх явдал ч бас орно.


Торгууль ногдуулах, лицензийг цуцлахаас өмнө лицензийг нь яагаад цуцалж болохгүй тухай тайлбар, үндэслэлийг Уул уурхайн яаманд гаргаж өгөх боломжийг лиценз эзэмшигчид олгох ёстой. Энэ нь олон орны захиргааны эрх зүйд байдаг “ жам ёсны шударга зарчим” -д нийцнэ. Эдгээр нь дараах зарчмууд юм. Үүнд:

- Буруутгах үндэслэл бүхий мэдэгдлийг компани эсвэл хувь хүнд өгсөн байна.
- Мэдэгдэлд хариу өгөх боломжийг тэдэнд олгоно.
- Шийдвэр гаргагч (сайд, хариуцсан албан хаагч, шүүгч гэх мэт) нь тухайн хүн эсвэл компанитай ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой.

Практик дээр Яам нь “Сайд өнөөдөр шөнийн 12 цагт лицензийг чинь цуцлах шийдвэр гаргалаа” гэсэн мэдэгдэлийг компанид илгээж болохгүй. Энэ жишээн дээр мэдэгдэлд лиценз цуцлах үндэслэл (шалтгаан)-ийг заагаагүйгээс гадна компани уг мэдэгдэлд хариу өгөх боломж олгоогүй байна. Бид ажилтан нь энэ жишээн дээр ашиг сонирхолын зөрчилтэй байсан эсэхийг мэдэхгүй ч дээр дурдсан шударга ёсны эхний хоёр зарчмыг хангаагүй тул хардаж болох юм.

Нийцлийг хангуулах зохион байгуулалтын бүтэц

Австралийн ихэнх мужид хууль тогтоомжийн нийцлийг хангуулах чиг үүрэг бүхий ажилтны тоо нь лиценз хүссэн өргөдлийг шийдвэрлэхэд оролцох ажилтны тооноос ерөнхийдөө их байдаг. Хэдийгээр муж тус бүр нь харилцан адилгүй боловч "Уул уурхайн яам" -ны зохион байгуулалтын бүтэц нь Зураг 5-д харуулсантай ижил байна.



Зураг 5. Байгууллагын бүтэц

Тэмдэглэл. Дээрх зурагт эрх, тусгай зөвшөөрөл олгодог албыг дүрэм журмын биелэлтийг хянадаг албадаас тусад нь харуулсан бөгөөд энэ нь байж болох хамгийн сайн бүтэц юм. Хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, стратегийн бодлого, статистик зэрэг туслах бүтцийг багтаагаагүй болно.

БАРУУН АВСТРАЛИ

Хууль эрх зүйн орчин

Баруун Австралид (БА) ашигт малтмалын хайгуул, олборлолтыг *1978 оны Уул уурхайн хууль* (Уурхайн Акт) ба *1981 оны Уул уурхайн журмын* дагуу зохицуулдаг. Уул уурхайн хуулиар ашигт малтмалын хайгуул, олборлолт хийхийг хүсч буй компаниудад тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоосон байдаг. Баруун Австрали нь нүүрс, уран зэрэг ашигт малтмалтай. Уул уурхайн хуульд хэд хэдэн эрх зөвшөөрлийн талаар⁷, тусгасан боловч доор эрэл ба хайгуулын лицензийн талаар өгүүлнэ.

Ашигт малтмалын эрэл ба хайгуулын лицензийг зөвхөн 'түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх' зарчмын үндсэн дээр олгодог.

Ашигт малтмалын талбай

Баруун Австрали нь 2500,00 км² талбай бүхий газар нутагтай ба энэ нь ашигт малтмалын талбай, дүүргүүдэд хуваагддаг бөгөөд тэдгээрт тус бүрийг нь хариуцсан уул уурхайн бүртгэлийн алба ажилладаг. Лиценз авах өргөдлийг уул уурхайн бүртгэлийн албанд биечлэн, эсвэл Mineral Titles Online (МТО) системээр цахим хэлбэрээр илгээж болно. Одоогийн байдлаар өргөдлийн 85 гаруй хувийг цахимаар ирүүлж байна.

Хянагч

Хянагч нь уул уурхайтай холбоотой асуудлыг шийдвэрлэхээр томилогдсон ердийн шүүгч юм. Ашигт малтмалын талбай тус бүрийг хариуцсан Хянагч байх бөгөөд нэг шүүгч хэд хэдэн ашигт малтмалын талбай, дүүргийг хариуцсан Хянагч байж болно. Хянагчдийн шүүх ажиллах заалтыг Уул уурхайн хуульд тусгасан бөгөөд шүүгчийн алба хашиж буй аливаа этгээдийг Хянагчдийн шүүхийг тэргүүлэх Хянагчаар томилж болно.

Хянагчийн үүргийг анх Виктория мужийн 1852 оны Уурхайн тухай хуульд тодорхойлсон бөгөөд лиценз авах өргөдөл гаргах, лиценз цуцлах, зардлын нөхцлөөс чөлөөлөх гэх мэт бүхий л процессийг муж доторх бүх асуудлаар шийдвэр гаргах эрхтэй. Хянагчийн шүүхээр шийдвэрлэдэг тул Баруун Австралид онцгой хамааралтай. Хянагчийн шүүхийн шийдвэр нийтэд нээлттэй байдаг.

Хянагч нь хоёр үүрэг гүйцэтгэдэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй:

- Захиргааны хэргийг шүүх, гуравдагч этгээдийн зүгээс лиценз олгохыг эсэргүүцсэн тохиолдолд Сайд эсвэл Сайдын төлөөлөгчдөд (төрийн өндөр албан тушаалтан) зөвшөөрөл олгох эсэх асуудлын талаар зөвлөмж өгөх.
- Лиценз эзэмшигчдийн хооронд үүссэн иргэний маргааныг хянан хэлэлцэх шүүхийн үүрэг.

"Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх" зарчмыг тэргүүлэх чиглэл болгох нь

Хэрэв нэг талбай буюу түүний хэсэгт хайгуулын лиценз хүссэн нэгээс илүү өргөдөл ирсэн бол өргөдөлтэй холбоотой "анхны шаардлагыг түрүүлж хангасан" өргөдөл гаргагч нь лиценз авах давуу эрхтэй байна.

Эрэлийн лиценз хүссэн өргөдөл хүлээж авсан тохиолдолд энэ нь Уул уурхайн тухай хуулиар

⁷<http://dmp.wa.gov.au/Minerals/Mining-Tenements-explained-5145.aspx>

урьдчилж тодорхойлсон дагуу тухайн талбайн хилийг тэмдэглэнэ (лицензийн талбайн хил хязгаарыг тэмдэглэж гадас зоох үед цаг / огноог тэмдэглэх) гэсэн үг юм. Хянагч өрсөлдөж өргөдөл гаргагчдын 'шалгуур' буюу чадавхийг (санхүүгийн эсвэл техникийн) харгалзан үзэхээс татгалзсан тохиолдолд давуу эрх олгох зарчимд шүүхийн шийдвэрийг баримтална.

Хайгуулын лиценз авахаар өрсөлдөж байгаа тохиолдолд талбайг тодорхойлоход торон эсвэл блокон хэмжээс (Австралийн Геодезийн мэдээллийн сан дээр үндэслэсэн, 3 км² орчим талбайтай) ашиглах бөгөөд Бүртгэлийн алба эсвэл Хянагчийн зүгээс хоёр ба түүнээс дээш өргөдөл гаргагч 'анхны шаардлага' -ыг 'нэгэн зэрэг эсвэл тогтоосон хугацаанд' зэрэг хангасан гэж үзэж байвал санал хураах замаар шийдвэр гаргана.

Ихэнх өргөдлийг МТО-р дамжуулан ирүүлэх ба лиценз эзэмшигч хуулийн дагуу талбайг буцаасан, хугацаа дуусгавар болсон эсвэл цуцалсан нэг талбайд "зэрэг эсвэл тодорхойлсон хугацаанд" хоёр ба түүнээс олон өргөдөл гаргах тохиолдлууд гарна. Лицензийн хугацаа шөнийн 00 цагт дуусгавар болсон гэж үзвэл шөнийн 00 цагаас өглөөний 08 цаг 30 минутын хооронд (ажил эхлэх үед) цахимаар илгээсэн өргөдлүүдийг өглөөний 08 цаг 30 минутад ирүүлсэн гэж үзэх бөгөөд хэд хэдэн өргөдөл ирсэн байх боломжтой. Энэхүү тогтолцоо нь өглөөний 08:30-д өргөдлийг цаасан хэлбэрээр ирүүлж шөнийн цагаар цахимаар ирүүлсэн өргөдлүүдтэй санал хураалтад өрсөлдөх боломжийг бүрдүүлэхэд зориулагдсан.

Өргөдлийг "нэгэн зэрэг" ирүүлсэн гэдэг үг хэллэгийн утгыг хуульд маш нарийвчлан ойлгодог бөгөөд Хянагч ч 28 секундын зайтай ирүүлсэн хоёр өргөдлийг "нэгэн зэрэг" ирүүлсэн гэж үзээгүй тохиолдол бий; гэсэн хэдий ч 'нэгэн зэрэг' гэдэг нь 'яг нэг миллисекундэд' гэсэн үг биш юм. Хоёроос таван секундын зайтай илгээсэн өргөдлүүдийг санал хураах замаар шийдвэрлэдэг.

'Түрүүлж ирсэнд нь түрүүлж үйлчлэх' зарчмын гол онцлог нь өрсөлдөж буй өргөдлүүдийг эрэмбэлэх шийдвэр гаргах эрхийг Сайд эсвэл Хянагчгаас холдуулах явдал юм.

Шийдвэр гаргах процесс болон 'Түрүүлж ирсэнд нь түрүүлж үйлчлэх' зарчмыг хэрэгжүүлэхэд Хянагчийн Шүүх чухал ач холбогдолтой гэдгийг анхаарах хэрэгтэй бөгөөд эдгээр хүчин зүйлс нь Фрейзерийн хүрээлэнгээс жил бүр зохион байгуулдаг дэлхийн уул уурхайн хөрөнгө оруулалтын таатай орчны судалгаагаар Баруун Австралийг дэлхийн тэргүүлэх 5 улсын нэг болоход нөлөөлж байна гэж тус тайланд үзэж байна.

Урьдчилж баталсан маягт

Баруун Австралид бүх өргөдлийн маягтыг "урьдчилж тодорхойлсон" биш ч гэлээ хэлбэр загварын хувьд журамд заасан дагуу "маш тодорхой" байхаар боловсруулж хуульчлан батлуулдаг.

Урьдчилж тодорхойлсон маягтыг⁸ Уул уурхайн тухай хуулийн холбогдох зүйл заалт, хамаарах журмыг ишлэсэн байдаг.

Баруун Австралд лицензийн болзол нөхцөлийн нийцлийг урьдчлан тодорхойлсон маягтын дагуу тайлагнах үүрэгтэй, гэхдээ ихэнх маягт онлайн байдаг тул хэрэглэгч Яамны мэдээллийн санд мэдээллийг оруулах боломжтой. Бүрэн бус эсвэл буруу бөглөсөн маягтыг шаардлага хангах хүртэл лицензийн бүртгэлд оруулахгүй.

Жишээлбэл, заавал биелүүлэх нөхцөл болох 5-р маягтаар гаргах үйл ажиллагааны тайланг буруу эсвэл дутуу ирүүлбэн тайланг хүлээж авсан гэж үзэхгүй. Энэ нь тайланг хугацаа хожигдуулсан гэж үзэж лицензийг хүчингүй болгоход хүргэж болзошгүй юм. "Нийцэл хангахыг" нь хатуу дагаж мөрдөхийг ерөнхийдөө хэрэглэдэггүй Квинслэндээс ялгаатай нь БА -д энэ нь ноцтой үр дагаварт

⁸ <http://www.dmp.wa.gov.au/Minerals-Mining-16304.aspx>

хүргэж болно. Зардал болон үйл ажиллагаа хоёуланг нь багтаасан Үйл ажиллагааны тайлангийн Маягт 5 -ыг Хавсралт 1 -д үзүүлэв.

Эрлийн лиценз

Эрлийн лицензийг харьцангуй бага хэмжээтэй талбайд ашигт малтмалын эрэл хийх зорилгоор олгодог бөгөөд хамгийн ихдээ 200 га талбайг хамрах боломжтой. Эрлийн лиценз эзэмшигчид ашигт малтмал хайх зорилгоор газарт нүх, шурф, суваг малтах, цооног гаргах, штрек нэвтрэх зэрэг үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг. Эрлийн лиценз эзэмшигч нь заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр (лицензийн хугацаанд нийт 500 тонн) газар шороо, хөрс, чулуу, чулуулаг малтах эрхтэй, гэхдээ ашигт малтмалын олборлолт хийхийг зөвшөөрдөггүй.

Эрлийн лиценз авахын тулд геологийн үндэслэл, эрэл хийх арга, өргөдөл гаргагчийн техникийн болон санхүүгийн чадавхийг батлах баримт ирүүлэх шаардлагагүй болно.

Эрэл хийх лицензийн дагуу олгогдох эрх

- Эрэл хийх лицензийг эхлээд дөрвөн жилийн хугацаатай олгодог бөгөөд дахин дөрвөн жилээр нэг удаа сунгаж болно (өөрөөр хэлбэл дөрөв дөрвөн жилээр нийт найман жилийн хугацаагаар олгодог).
- Хамгийн их талбай нь 200 га.
- Лицензийг 8 жилээс дээш хугацаагаар хадгалахын тулд лиценз хадгалах нөхцөлийн тухай өргөдөл гаргах ёстой; Лицензийг хадгалах нөхцөлийг нотлохын тулд ашигт малтмалын нөөц тогтоогдсон эсэх, ашиглах лиценз авахыг хүсэхгүй байгаа шалтгаан, үндэслэлийг харгалзана.
- Олборлолт хийхийг зөвшөөрөхгүй.
- Эрэл хийх лиценз эзэмшигч нь лицензийн талбайд онцгой эрхээр олборлолт хийх хүсэлт гаргах эрхтэй.

Болзол нөхцөл

Хянагч эсвэл уул уурхайн бүртгэлийн алба нь эрэл хийх лиценз олгохдоо стандарт нөхцлөөс гадна нэмэлт болзол тавьж болно. "Ажлын төлөвлөгөө" (байгаль орчны зөвшөөрөл) –нд Яамаар үнэлгээ хийлгэж, хураамж төлөөгүй, уг төлөвлөгөөг батлуулаагүй тохиолдолд газар хөндөх тоног төхөөрөмж ашиглах боломжгүй.

Эвдсэн газрыг нөхөн сэргээсэн тухай тайланг тодорхой хугацааны дотор өгөх шаардлагатай. Гал түймэр, ургамал, эд хөрөнгө, малд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх нэмэлт нөхцлүүд байж болно.

Зардал ба тайлагнал

Эрлийн лиценз эзэмшигч нь чөлөөлөгдөх нөхцөлөөс бусад тохиолдолд урьдчилж тодорхойлсон, зардал гаргах нөхцлийг хангах ёстой (урьдчилж тодорхойлсон зарлагын доод хэмжээний хураангуйг Хүснэгт 3 -аас үзнэ үү).

Тухайн газарт эрэл хийхтэй холбогдуулан хийсэн бүх ажил, зардал багтаасан тайлан гаргах ёстой. Зардалыг лиценз олгосон өдрөөс хойш нэг жил өнгөрсөний дараах 60 хоногийн дотор Маягт 5 -аар тайлагнах ёстой. Зардалыг тайлагнахгүй байх нь лицензийг цуцлах үндэслэл болж болно.

Хайгуулын лиценз

Тойм

Хайгуулын лиценз (ХЛ) нь эрлийн лицензтэй харьцуулахад урт хугацаанд том талбайд хайгуул хийх эрх олгоно. Зургаан жилийн дараа талбайн 40% -ийг заавал буцаах шаардлагатай.

Хайгуулын лицензээр бүх төрлийн ашигт малтмал хайх зорилгоор газар нутагт нэвтрэх эрхийг лиценз эзэмшигчид олгодог. Лиценз эзэмшигч нь урьдчлан тогтоосон хэмжээнээс хэтрэхгүйгээр (лицензийн хугацаанд нийт 1000 тонн) хөрс, чулуу, чулуулаг малтах, ил гаргаж овоолох боломжтой боловч ашигт малтмал олборлох эрхгүй.

Хайгуулын лицензийг эрдэсжсэн талбайд (хүрэн талбайд) хамгийн бага нь нэг блок⁹

(Австралийн геодезийн мэдээлэлд үндэслэн 3км² орчим), хамгийн их нь 70 блок, эрдэсжсэн талбайн гадна (ногоон талбай) 200 блок талбай олгодог.

Хэрэв ХЛ -ийн талбай нь арав (10) ба түүнээс дээш блок бол лиценз эзэмшигч нь 6 дахь жил дуусахаас өмнө ХЛ -ийн хугацааг сунгах үед талбайн 40 хувийг заавал буцаах ёстой.

Лиценз авах өргөдөлд хайгуул хийх арга, хийх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, хайгуулын ажлын зардал, өргөдөл гаргагчийн техникийн болон санхүүгийн чадавхийн талаарх танилцуулга зэрэг материал хавсаргасан байх ёстой.

Геологичид буюу геологийн алба нь өргөдлийг шийдвэрлэхэд оролцохгүй тул хайгуул хийхэд зориулж геологийн нарийвчилсан үндэслэл гаргах шаардлагагүй.

Хайгуулын лицензийн дагуу олгогдох эрх

- ХЛ -ийг бүх төрлийн ашигт малтмал хайхаар олгодог.
- ХЛ-ийг эхлээд таван жилийн хугацаатай олгодог бөгөөд 5 жилээр нэг удаа, дараа нь 2 жилээр нэг ба түүнээс дээш удаа сунгаж болно.
- Олборлолт хийхийг зөвшөөрөөхгүй.
- ХЛ эзэмшигч нь онцгой эрхээр лицензийн талбай дотор ашигт малтмал олборлох ашиглалтын лиценз авах хүсэлт гаргах эрхтэй.

Болзол нөхцөл

Эрэлийн лицензтэй нэгэн адил Хянагч эсвэл уул уурхайн бүртгэлийн алба нь хайгуулын лиценз олгохдоо үндсэн нөхцлөөс гадна нэмэлт болзол тавьж болно. "Ажлын төлөвлөгөө" (байгаль орчны менежментийг багтаасан тайлан) - Яамаар үнэлгээ хийлгэж, хураамж төлөөгүй, уг төлөвлөгөөг батлуулаагүй тохиолдолд газар хөндөх тоног төхөөрөмжийг ашиглаж болохгүй. Эвдсэн газрыг нөхөн сэргээсэн талаарх тайланг тодорхой хугацааны дотод ирүүлэх шаардлагатай. Гал түймэр, ургамал, эд хөрөнгө, малд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх нэмэлт нөхцлүүд хамаарч болно.

Зардал ба тайлагнал

ХЛ -ийн эзэмшигч нь чөлөөлөгдөх онцгой нөхцлөөс бусад тохиолдолд урьдчилж тодорхойлсон

⁹ Because Блок are based on latitude and longitude, a block varies in Хэмжээ from the north of the State to the south, a distance spanning 21.5 degrees in latitude. This means the 70 block maximum Хэмжээ of an EL will vary from approximately 196 km² in the south, to about 231 km² in the north of the State.

зардал гаргах нөхцлийг хангах ёстой (урьдчилж тодорхойлсонсон зардлын доод хэмжээний хураангуйг Хүснэгт 3 -аас үзнэ үү).

Тухайн талбай дээр хайгуул хийхтэй холбогдуулан гүйцэтгэсэн бүх ажил, зарцуулсан хөрөнгийн хэмжээг илэрхийлсэн тайлан (Үйл ажиллагааны тайлангийн Маягт 5) -г ирүүлэх ёстой. Маягт 5 нь зардалын тайлангаас гадна холбогдох гео шинжлэх ухааны хайгуулын мэдээлэл бүхий техникийн тайланг лиценз олгосон өдрөөс хойш нэг жилийн дараах 60 хоногийн дотор геологийн албанд ирүүлэх ёстой. Тайлагнах шаардлагыг биелүүлэхгүй байх нь лицензийг цуцлах үндэслэл болж болно.

Төлбөр

Эрэл болон хайгуулын лицензийн төлбөрийг жил бүр урьдчилж төлнө. Лицензийн эхний жилийн төлбөрийг өргөдөл гаргах үед төлнө. Лицензийн дараа, дараагийн төлбөрийг лиценз олгосон өдрөөс хойш нэг жилийн дараах сарын дотор төлөх ёстой.

Жилийн төлбөрийг төлөхгүй байх нь лицензийг цуцлах үндэслэл болно. Лиценз эзэмшигч нь лиценз цуцлах, буцаах, хугацаа дуусгавар болох зэргээс үл хамаарч жилийн төлбөрийг бүрэн төлөх үүрэгтэй. Жишээлбэл, лицензийг 2015 оны 7 -р сарын 1 -нд олгоод лиценз эзэмшигч 1580 ам. долларын лицензийн төлбөрийг 2016 оны 7 -р сарын 31 -ний дотор төлөх үүрэгтэй бөгөөд 2016 оны 8 -р сарын 31 -нд лицензээ буцааж өгсөн бол лиценз эзэмшигчийн 1,580 ам.доллар төлөх үүрэг хэвээр байх болно.

Хүснэгт 3. Эрэл хайгуулын болон хайгуулын лицензийн гол онцлогууд

	Хамгийн дээд талбай	Хугацаа (жил)	Хураамж		Жилийн хамгийн доод
			Өргөдөл	Төлбөр	
Эрэл хийх лиценз	200	4 жил. Нэг удаа 4 жилээр сунгах боломжтой	\$37	Га тутамд \$3, доод төлбөр \$29.50.	Га тутамд \$40, доод төлбөр \$2000.
Хайгуулын лиценз	70 блок, 200 блок (эрдэстэй талбайн гадна)	5 жил, 5 жилээр, дараа нь 2 жилээр сунгах боломжтой	Зөвхөн 1 блок, \$394. Нэгээс илүү блок \$1580	1 блок, \$369. Бусад лиценз блок тутам: 1-3 жил \$141, 4-5р жил \$238, 6-7р жил \$325	1-3-р жил Блок тутамд \$1,000, Доод \$10,000 \$15,000 - 2-5 Блок Доод \$20,000 - 6-20 Блок 4-5-р жил Блок тутамд \$1,500, Доод \$10,000 - 1 блок Доод \$20,000 - 2-5 Блок Доод \$30,000- 6-20 Блок 6-7-р жил Блок тутамд \$2,000, Доод \$15,000 - 1 блок Доод \$30,000- 2-5 блок Доод \$50,000- 6-25 блок 8+ жил Блок тутамд \$3,000, Доод \$20,000 - 1 блок Доод \$50,000- 2-5 блок Доод \$70,000 - 6-23 блок

Хайгуулын тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргах үйл явц

Аливаа лиценз авах өргөдлийг "Уул уурхайн эрхийн өргөдөл"-ийн Маягт 21¹⁰ -ыг бөглөж, уул уурхайн бүртгэлийн албанд эсвэл МТО¹¹ -ээр дамжуулан цахим хэлбэрээр ирүүлнэ. МТО -ийг ашиглахаас өмнө талууд МТО -д бүртгүүлж нэвтрэх эрх авсан байна. Бүртгэл үнэ төлбөргүй хийгдэнэ.

Tenepgraph¹² онлайн газрын зургийн систем нь лицензийн талбайн байршлыг (түүний дотор газрын тосны талбайг) газрын бусад мэдээлэлтэй хамт харуулдаг. Уг систем нь ашиглалтын лиценз олгосон газрын цаг үеийн бодит зургийг харуулах ба түүнийг ашигт малтмалын хайгуул хийх боломжтой газрыг тодорхойлоход ашигладаг. Tenepgraph нь газрын зураг дээр суурилсан уул уурхайн лицензийн бүртгэлийн онлайн (МТО) систем юм.

Торолсон блок бүр давтагдашгүй лавлах дугаартай тул хайгуулын лицензийг биетээр тэмдэглэх шаардлагагүй болно. Өргөдөл дээр хайгуулын лицензийн талбайн хил хязгаарыг лавлах дугаараар тодорхойлно.

Яам нь бүртгэлийн ажилтнууд болон шийдвэр гаргагчид туслах зорилгоор өргөдөл шийдвэрлэхээс (зөвшөөрөх эсвэл татгалзах шийдвэр гаргах) өмнө процессийн алхам тус бүрийн гүйцэтгэлийг шалгах хяналтын хуудас ашигладаг. Үүнийг Хавсралт 2 -т харуулав.

Хайгуулын тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахад тавигдах шаардлага

Өргөдөл гаргахдаа 1978 оны Уул уурхайн тухай хуулийн 58 -р зүйлд заасан дараах баримт бичгийг хавсаргана.Үүнд:

- Хайгуул хийхэд ашиглахаар санал болгож буй арга (зөвхөн хураангуй байдлаар).
- Ажлын төлөвлөгөөний тухай мэдээлэл (зөвхөн хураангуй байдлаар).
- Лицензийн талбайд зарцуулахаар санал болгосон зардлын тооцоо. Олон тохиолдолд өргөдөл гаргагчид лицензийн талбайд зарцуулах хамгийн доод зардлын хэмжээг мэдүүлдэг.
- Өргөдөл гаргагчийн техникийн болон санхүүгийн чадавхи.

Хавсралт материал тус бүрийг үнэлэх тухай Яамны зааврын нарийвчилсан тайлбарыг "Өргөдөл гаргагчдад зориулсан заавар - Хэсэг 58 (1) (b) Хайгуулын лицензийн өргөдлийг дагалдах мэдэгдэл" баримт бичигт тусгасан¹³.

Мэдэгдэл хүргүүлэх

Өргөдлийг уул уурхайн бүртгэлийн алба хүлээн авсны дараа өргөдөл гаргагч нь өргөдөл гаргаснаас хойш 14 хоногийн дотор Маягт 21 -ийн хуулбарыг газрын зурагийн хамт дараах талуудад хүргүүлнэ. Үүнд:

- Бэлчээрийн¹⁴ газар түрээслэгч.
- Хувийн эзэмшлийн газар хөндөгдөх тохиолдолд нутгийн засаг захиргаа, газар өмчлөгч, эзэмшигч, хувийн газар барьцаалагч бүрт.

¹⁰ All forms are contained in the WA Mining Regulations

¹¹ <http://www.dmp.wa.gov.au/Mineral-Titles-online-MTO-1464.aspx>

¹² <http://www.dmp.wa.gov.au/Utilities/Frequently-Asked-Questions-3853.aspx>

¹³ http://www.dmp.wa.gov.au/Documents/Minerals/Guidelines_for_Applicants_Section_58_Statement_to_accompany_applications_for_Exploration_Licences.pdf

¹⁴ Pastoral Leases are leases over Government land for 99 years for grazing of animals, usually cattle or sheep

- Хэрэв өргөдөл нь бусад төрлийн лиценз¹⁵ -д нөлөөлж байвал бусад төрлийн лиценз эзэмшигчдэд.
- Хайгуулын лиценз хүссэн өргөдөлтэй холбоотой бусад төрлийн лиценз хүссэн өргөдөлд нөлөөлөх аливаа ашиглалтын лиценз эзэмшигч,эсвэл өргөдөл гаргагчдад.

Эдгээр талууд лиценз олгохын эсрэг санал гаргах боломжтой ба түүнийг Хянагч хүлээн авч шийдвэрлэнэ (доор тайлбарласан болно).

Нийцлийн тухай албан нотолгоо

Өргөдөл гаргагч нь Уул уурхайн тухай хууль ба журмын шаардлагыг хангасан тухай бичгээр нотолгоо гаргах ёстой.Уг албан нотолгоонд дараахь зүйлс багтана. Үүнд:

- Бүх мэдэгдлийг хүргүүлсэн тухай мэдээлэл.
- Тухайн өргөдөл нь Уул уурхайн тухай хууль, журмын холбогдох болзол нөхцөлийг хангасан тухай мэдэгдэл (хамааралтай бол, тухайлбал, эрлийн лиценз).
- Хувийн эзэмшлийн газар хөндөгдсөн бол олгогдсон нэвтрэх зөвшөөрлийн дугаар.
- Хайгуулын лиценз авах өргөдөл гаргасан тохиолдолд 58 дугаар Хэсэгт заасан мэдэгдэл.

Албан нотолгоог бүх мэдэгдлийг хүргүүлсэний дараа гаргадаг бөгөөд лиценз авах өргөдлийн төрөл бүрт өөр өөр нотолгоо гаргадаг.

Гомдол ба эсрэг санал

Өргөдөл гаргаснаас хойш 35 хоногийн дотор уул уурхайн бүртгэлийн албанд эсвэл МТО -аар дамжуулан цахим хэлбэрээр эсрэг санал гаргаж болно.

Эсрэг санал ба лицензийн өргөдөлийг шийдвэрлэх

Эсрэг саналыг Хянагч шүүхийн танхимд хэлэлцэхээр шийдвэрлээгүй бол түүнийг Хянагч нээлттэй шүүхийн хуралдаанаар сонсож шийдвэрлэнэ. Бусад бүх асуудлыг шийдвэрлэж дууссаны дараа Сайд өргөдлийг эцэслэн шийдвэрлэнэ. Сайд нь Хянагчийн дүгнэлтийг үл харгалзан саналыг хүлээн авах эсвэл татгалзах боломжтой.

Баруун Австралийн эрэл, хайгуулын тусгай зөвшөөрөл авах өргөдлийг шийдвэрлэх процессийн тоймыг Зураг 6 -аас үзнэ үү.

Эсрэг саналгүй лицензийн өргөдөлийг шийдвэрлэх

Хэрэв лиценз авах өргөдлийн эсрэг ямар нэгэн эсрэг санал ирээгүй бол дараах журмын дагуу өргөдлийг шийдвэрлэнэ. Үүнд:

- Хайгуулын лиценз авах өргөдлийн хувьд уул уурхайн бүртгэлийн алба нь өргөдөл хүлээн авах эсвэл татгалзах саналыг Сайдад хүргүүлнэ.
- Сайд уул уурхайн бүртгэлийн албаны саналыг үл харгалзан өргөдөл хүлээн авах эсвэл татгалзах шийдвэр гаргах боломжтой. Гэвч бодит практик дээр Сайд энэхүү бүрэн эрхээ маш ховор хэрэглэдэг (ойролцоогоор 20 жилд нэг удаа онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд).

¹⁵ *Miscellaneous licences are mining tenements used for infrastructure associated with exploration and mining such as power line corridors, pipeline corridors, roads, airstrips etc which may cross tenements belonging to third parties*

Эрх, зөвшөөрөл олгох Австралийн журам Монгол Улсад хэрэглэхгүй нь ойлгомжтой.


Хайгуулын лицензийн үйл ажиллагааны байгаль орчны зөвшөөрөл

Хайгуулын лиценз олгосны дараа Уул уурхайн тухай хуульд заасан дагуу Ажлын төлөвлөгөөг (энэ нь үндсэндээ байгаль орчны зөвшөөрөл юм) цахимаар эсвэл цаасан хэлбэрээр гаргаж, механик тоног төхөөрөмж ашиглан газар хөндөх аливаа үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө батлуулах ёстой.

Ажлын төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатай батална. Газар хөндөх үйл ажиллагаа дууссаны дараа эсвэл лиценз сунгуулсаны дараа зургаан сарын дотор нөхөн сэргээлт хийх ёстой. Дараа нь нөхөн сэргээлтийн тайланг ирүүлэх ёстой.

Унаган ургамал хөндөхийн тулд Унаган ургамал хөндөх зөвшөөрөл (NVCP) авах шаардлагатай.

Тусгай хамгаалалтын газар болон бусад байгаль орчны хамгаалалтын бүсийг хөндөхөөс бусад тохиолдолд Ажлын төлөвлөгөө, Унаган ургамлыг хөндөх зөвшөөрлийг Баруун Австралийн Уул уурхайн яам баталж олгодог.



Зураг 6. Эзэмшил бүхий газрын эрх авах өргөдлийн процесс

КҮИНСЛАНД

Эрх, зөвшөөрөл авах өргөдөл гаргах эрх зүйн орчин

Күинсланд мужид ашигт малтмал, нүүрсний хайгуулын ажлыг 1989 оны Эрдэс баялгийн тухай хууль (ЭБ-ын тухай хууль), 2013 оны Эрдэс баялгийн тухай журамаар зохицуулдаг. Эрдэс баялгийн тухай хууль нь ашигт малтмал, нүүрсний хайгуул, олборлолт хийхийг хүсч буй компаниудын дагаж мөрдөх үйл явц, шаардлагыг тодорхойлдог бөгөөд үүнд эхлээд ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл (АМХЗ) эсвэл нүүрсний хайгуул хийх зөвшөөрөл (НХЗ) -ийг холбогдох яамны сайд олгодог.

Күинсланд нь лицензийг "түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх" (FCFS) ба сонгон шалгаруулалт зэрэг хоёр аргаар олгодог. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процесс нь эрдэс бүтээгдэхүүний төрөл, холбогдох хууль тогтоомж зэргээс хамаарна (Хүснэгт 4 -ийг үзнэ үү).

Хүснэгт 4. Күинсландийн лиценз олгох механизм

Ашигт малтмал	Хууль	Сонгоноор	Өргөдлөөр
Нүүрс	1989 оны Эрдэс баялгийн тухай хууль	Тийм	Үгүй
Ашигт малтмал /нүүрснээс бусад/	1989 оны Эрдэс баялгийн тухай хууль	Тийм	Тийм

Күинсландад түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх аргыг зөвхөн ашигт малтмалд ашигладаг бөгөөд сонгон шалгаруулалтын аргыг нүүрс, газрын тос, ашигт малтмалын төрөлд ашигладаг (жишээлбэл, Баруун хойд ашигт малтмалын бүс¹⁶ зэрэг зарим нутаг дэвсгэрийн нэгжид).

Сонгон шалгаруулалтын үйл явц нь тусгай шалгуур, болзол нөхцлийг хэрэглэн өргөн хүрээний бодлогын асуудал, үр дүнг хангадаг бөгөөд сонгон шалгаруулалт зарлахын өмнө засгийн газрын зүгээс бүрэн хэмжээний төлөвлөлт ба зохицуулалтыг шаарддаг, үүнд Күинсландын геологийн (GSQ) албанаас бэлтгэдэг гео шинжлэх ухааны урьдач өгөгдөл мэдээллийн багц мөн багтана.

Хайгуулын зөвшөөрөл

Хайгуулын зөвшөөрөл (ХЗ) авсан этгээд нь зөвшөөрлийн талбайд нэвтэрч (тусгай зөвшөөрөл нөлөөлсөн газар өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрлөөр), ашигт малтмалын хэмжээ ба чанарыг тодорхойлохын тулд зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулах эрхтэй. Үүнд зөвшөөрөгдсөн талбайн газрын хэвлий дэх аливаа ашигт малтмал (нүүрс бас орно) хамаарна. ХЗ нь ашигт малтмал олборлох бус зөвхөн хайгуулын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг.

Хайгуулын зөвшөөрлөөр олгогдох эрх

- Хайгуулын зөвшөөрлийг дээд тал нь таван жилийн хугацаатай олгодог бөгөөд газарт нэвтрэх эрхийн шаардлагыг хангасан тохиолдолд эзэмшигч нь зөвшөөрөгдсөн талбайн дотор хайгуулын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг.
- Олборлолт хийхийг зөвшөөрөхгүй.
- Хайгуулын зөвшөөрлийг өргөдөл гарган сунгуулж болно.
- Хайгуулын зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн талбайд ашигт малтмал олборлох эрх авах хүсэлт гаргах онцгой эрхтэй (урьдчилсан зөвшөөрөл).

¹⁶ <https://www.statedevelopment.qld.gov.au/regions/regional-priorities/strategic-blueprint-nwmp>

Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх зарчим нь ерөнхийдөө Квинсландын нүүрснээс бусад ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөлд үйлчилнэ. Өргөдлийг Эрдэс баялгийн тухай хууль ба журамд заасан батлагдсан маягтаар ирүүлэх ёстой бөгөөд талбай ба түүний байршил, хайх ашигт малтмал, санал болгож буй хайгуулын ажлын төлөвлөгөө ба зардалын тооцоо болон ажлын төлөвлөгөөг гүйцэтгэхэд шаардагдах хүний, техникийн болон санхүүгийн нөөцийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байх ёстой.

Хүснэгт 5. Хайгуулын зөвшөөрлийн үндсэн өгөгдлүүд

Ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөл		Нүүрсний хайгуулын зөвшөөрөл
Ашигт малтмал	Нүүрснээс бусад ашигт малтмал	Нүүрс
Хугацаа	0-5 жил /нэг удаад/	0-5 жил /нэг удаад/
Хэмжээ	100 дэд блок	Сонгонд хамаарах: 300 дэд блок НЗХ хамаарах: 6 дэд блок /хэрэгжиж буй төсөлтэй хиллэсэн/
Сунга боломжтой	Тийм	Тийм
Төлбөр	Дэд блок тутамд \$164.90	Дэд блок тутамд \$164.90
Өргөдөл гаргасны төлбөр	\$1,000	\$1,337

Өргөдөл гаргах журам

MyMinesOnline¹⁷ систем нь сонирхогч этгээдээс эрх ба зөвшөөрөл авахаар гаргасан өргөдөл онлайнгаар хүлээн авч шийдвэрлэдэг үндсэн арга юм. Мөн уг систем нь өргөдөл болон түүнийг шийдвэрлэх үйл явцын мэдээлэлтэй танилцах ба хянах, түүнчлэн нэмэлт баримт бичиг оруулах, төлбөр хийх боломжтой. Өргөдөл гаргагчид MyMinesOnline системд бүртгүүлж, өөрсдийгээ гэрчлэх баримт бичгийн баталгаат хуулбарыг байршуулах ёстой.

Өргөдлийг мөн шуудангаар болон биеэр тогтоосон маягтаар гаргаж болно (Хавсралт 3).

Сонирхогчид өргөдөл гаргахаас өмнө ашигт малтмалын хэтийн төлөвийг үнэлэхэд хэрэглэж болох ашиглалт ба хайгуулын өгөгдөл мэдээлэл бэлтгэдэг GeoResGlobe-тэй зөвлөлдөн сонирхсон газар нь хэр ирээдүйтэй болохыг шалгаж болдог¹⁸.

Өргөдөлд тавигдах шаардлага

Өргөдөл гаргагч бүр өөрсдийгээ гэрчлэх баримт бичгээс гадна дараах баримт бичгийг Яаманд ирүүлэх ёстой. Үүнд:

¹⁷ <https://www.business.qld.gov.au/industries/mining-energy-water/resources/minerals-Нүүрс/online-services/myminesonline>

¹⁸ <https://www.business.qld.gov.au/industries/mining-energy-water/resources/minerals-Нүүрс/online-services/georesglobe>

- Үйл ажиллагаанд суурилсан эсвэл үр дүнд суурилсан хайгуулын ажлын төлөвлөгөөний үндэслэл (Эрдэс баялгийн тухай хуулийн 130AA хэсэгт заасан дагуу).
- Санхүүгийн болон техникийн чадавхийн мэдэгдэл .
- Күинсланд дахь хайгуулын бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл.

Шаардагдаж болох бусад баримт бичиг:

- Эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг гэрчлэх баримт бичиг (MyMinesOnline -ийн хэрэглэгчээр бүртгүүлээгүй тохиолдолд).
- Байгаль орчны зөвшөөрөл авах өргөдөл, байгаль орчны хамгаалалттай газрын зургийн хамт.
- Техникийн үйлчилгээ үзүүлэх аливаа гуравдагч этгээдийг (жишээлбэл, зөвлөх, үйлчилгээний компани) мэдүүлэх баримт бичиг.

Өргөдөл гаргахад тавигдах бусад шаардлагууд:

Өргөдөл гаргагчийн мэдээлэл

Зөвшөөрөл эзэмшигч болохоор өргөдөл гаргагч этгээдтэй холбоо барих бүрэн мэдээлэл, үүнд Австралийн компанийн дугаар (ACN) орно. Хэрэв өргөдөл гаргагч нь компани байвал Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын хорооны бүртгэл дээрх компанийн тухай мэдээллийг оруулна.

Эрдэсжсэн талбайг сонгох – талбайн тухай танилцуулга

[Анхаарах: Энэ хэсгийг сонгон шалгаруулалтын журмаар өргөдөл гаргахад бөглөх шаардлагагүй. Сонгон шалгаруулалтын урилгад сонгоны талбайн танилцуулга аль хэдийн хийгдсэн байдаг.]

ХЗ авах өргөдлийг блок болон дэд блокууд дээр гаргана. Эдгээр блок ба дэд блокуудыг Австралийн геодезийн мэдээллийн сангийн өргөрөг, уртрагаар Block Identification Maps (BIMs)¹⁹ -д тодорхойлсон байдаг.

BIM тус бүр нь:

- Давтагдахгүй нэртэй бөгөөд дарааллаар нь дугаарласан 3456 блок агуулсан.
- Ойролцоогоор 75 хавтгай дөрвөлжин км талбайтай бөгөөд дэд блок бүр ойролцоогоор 3 хавтгай дөрвөлжин км талбайтай (блокийн яг хэмжээ нь газрын гадаргын дугуйралтаас хамаарна).
- Цагаан толгойн үсгийн дарааллаар тодорхойлсон 25 дэд блокт хуваагддаг ("i" үсэг орохгүй).
- Таван минутын өргөрөг, таван минутын уртраг, дэд блок нь нэг минутын өргөрөг нэг минутын уртрагтай тэнцэнэ.

Газрын боломж

ХЗ авах өргөдлийг дор дурдсанаас бусад бүх газарт гаргаж болно. Үүнд:

- Үндэсний парк болон хамгаалалтын бүсүүд

¹⁹ <https://www.data.qld.gov.au/dataset/queensland-mining-and-exploration-administration-series>

- Хайгуул хийхийг шууд хориглосон талбай (жишээлбэл, хууль тогтоомжоор олборлолт хийхийг зөвшөөрөөгүй улсын эзэмшлийн газар)
- Хязгаарласан газар
- Түр хориглосон газар
- Хүчин төгөлдөр зөвшөөрөл, ашиглалтын лицензтэй газар

Зөвшөөрлийн талбай нь тэргүүлэх ач холбогдолтой тариалангийн ба суурьшлын газар, байгаль орчны болон тариалангийн стратегийн газар, эсвэл тусгай хамгаалалттай газар нутагтай давхцаж байвал нэмэлт болзол нөхцөл тавьж болно.

Боломжгүй газрыг ихэвчлэн өргөдөл гаргах боломжтой талбайгаас хассан байна. MyMinesOnline нь хязгаарласан газарт зөвшөөрөл авах өргөдөл гаргахыг хориглохгүй; гэхдээ өргөдлийг хүлээн авсан бол газрыг ХЗ-ийн талбайгаас хасна.

1992 онд батлагдсан Күинсландын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 27-р хэсэгт улсын тусгай хамгаалалтын газар болон бусад хамгаалалтын бүсийг хамгаалах зорилгоор олборлолт, хайгуул хийхийг хориглосон газруудын жагсаалтыг гаргасан байдаг.

Түр хориглосон газар

Зөвшөөрлийн хугацаа дууссан талбайд, эсхүл ижил ашигт малтмалын өргөдлөөс татгалзсан эсвэл орхигдсон талбайд үйлчилж байсан түр хориглосон хугацаа дууссанаас хойш хоёр сарын дараа ижил ашигт малтмалын өргөдөл гаргаж болно.

Түр хориглосон газраас чөлөөлөгдсөн талбайд гаргасан хайгуулын өргөдлийн ажлын төлөвлөгөө нь Эрдэс баялгийн тухай хуулийн 134A (5) хэсэгт заасан дагуу үйл ажиллагаанд суурилсан төлөвлөгөө байх ёстой.

Хүчин төгөлдөр хайгуулын зөвшөөрлийн талбайд өргөдөл гаргах

Яам нь өөр ашигт малтмал (нүүрс үүнд орно)-д зориулсанаас, эсвэл одоогийн хайгуулын зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайг шинэ ХЗ-д зориулж буцаан өгсөнөөс бусад тохиолдолд хүчин төгөлдөр ХЗ-ийн талбайд давхардуулж өргөдөл өгөх боломжгүй.

ХЗ нь хүчин төгөлдөр ашиглалтын эрх, зөвшөөрөл, уурхай хөгжүүлэх лицензийн давхцаж болно; гэхдээ тухайн талбайг зөвшөөрөл олгохдоо хасч олгоно. Хэрэв тухайн зөвшөөрөл, лиценз нь хүчингүй болсон (хугацаа нь дууссан эсвэл буцаагдсан) зарим тохиолдолд тухайн талбайг хайгуулын зөвшөөрлийн талбайд нэмж оруулах боломжтой.

Шийдвэрлэгдээгүй байгаа өргөдлийн талбай нь өөр төрлийн ашигт малтмал хайх зөвшөөрөл хүссэнээс (жишээлбэл, нүүрсний ХЗ-ийн талбай дээр ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл авах өргөдөл гаргах) бусад тохиолдолд боломжгүй байна.

Талбайн хэмжээний хязгаарлалт

Сайд Эрдэс баялгийн тухай хуулийн 127 (4) дэх хэсэгт заасан дагуу өөрөөр зөвшөөрөөгүй бол нүүрсний ХЗ нь:

- 2013 оны Эрдэс баялгийн журмын 9(a) хэсэгт заасан дагуу хамрах талбай нь 300 дэд-блокоос (сонгон шалгаруулалт) хэтрэхгүй; эсхүл
- Эрдэс баялгийн тухай хуулийн 136Q(b)(iii) хэсэгт заасан дагуу зургаан дэд-блокоос (төсөлд хамаарах өргөдөл) хэтрэхгүй байх ёстой.

Ашигт малтмалын зөвшөөрлийн хувьд, тогтоосон дээд хэмжээнээс их талбай хүссэн

өргөдөл гаргагчийн үндэслэлийг Сайд авч үзээд өөрөөр зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд зөвшөөрлийн талбай 100 дэд блокоос хэтрэхгүй байх ёстой.

Хот суурин эсвэл суурьшлын газрын дэд блокийг хамарсан өргөдөлд түүнийг шийдвэрлэхээс нь өмнө газар ашиглалтын талаар гарч болзошгүй зөрчлийг хэрхэн багасгахыг тусгаж харуулсан ажлын төлөвлөгөө багтсан байх ёстой.

Ажлын төлөвлөгөө

Хугацаатай холбоотой нөхцөлийг зөвшөөрлийг олгох, сунгах үед түүн дээр тавина. Өргөдөл гаргагчаас санал болгож ирүүлсэн ажлын төлөвлөгөө нь зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой нөхцөлийн үндэс суурийг хангах аль ч цаг үед ажлын төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх боломжтой.

ХЗ-ийн хугацаанд хийх ажлын төлөвлөгөө нь үйл ажиллагаанд суурилсан эсвэл үр дүнд суурилсан байж болно. Үйл ажиллагаанд суурилсан ажлын төлөвлөгөө нь дараахь зүйлийг агуулсан баримт бичиг байна. Үүнд:

- Зөвшөөрлийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөөд буй үйл ажиллагаа;
- Зөвшөөрлийн хугацаанд хайгуул хийхэд зарцуулахаар тооцож төлөвлөсөн хүний, техникийн болон санхүүгийн нөөц.

Үйл ажиллагаанд суурилсан ажлын төлөвлөгөө нь дараах зүйлс шаардлана. Үүнд:

- Зөвшөөрлийн хугацаанд хийж гүйцэтгэх үйл ажиллагаа болон хайгуулын ажилд зарцуулах санхүүгийн эх үүсвэрийг багтаасан ажлын төлөвлөгөө
- Дараах мэдээллийг багтаасан ажлын төлөвлөгөөний нарийвчилсан үндэслэл бүхий баримт бичиг. Үүнд:
 - Хайгуулын загвар нь тухайн талбайд хайгуул хийгдсэн байдлыг харгалзан хэтийн төлөвийн үнэлгээг ахиулахыг ажлын төлөвлөгөөг хэрхэн тусгасан
 - Хайгуулын ажлыг хийх хугацаа, байршлын дэлгэрэнгүй мэдээлэл (GPS -ийн координат болон бусад тодорхой тэмдэглэгээгээр хугацаа, байршлыг нотлох шаардлагагүй - зөвхөн геологийн тогтоцтой холбоотой ерөнхий байршил байхад хангалттай)
 - Зорилтот хуримтлал болон хайгуулын ажлыг явуулах байршлыг харуулсан газрын зураг
 - ХЗ-ийн талбай дээр өмнө нь хийсэн хайгуулын ажил, илрүүлсэн ашигт малтмал, баялгийн талаарх мэдээлэл.
 - Санал болгосон хайгуулын ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвшөөрлийн талбайг тодорхойлсон үндэслэл
 - Хэрэв тухайн зөвшөөрөл нь өөр том төслийн бусад зөвшөөрөлтэй нийцэж байгаа эсвэл уг төслийн нэг хэсэг бол ажлын төлөвлөгөөнд уг төслийн хүрээнд хэрхэн ажиллах талаар тайлбарлаж, бусад зөвшөөрлүүдтэй ямар хамааралтай болохыг тодорхой харуулах ёстой;
 - Хэрэв холбогдолтой гэж үзвэл хийхээр дэд бүтцийн судалгааны талаархи мэдээлэл

Үр дүнд суурилсан хайгуулын ажлын төлөвлөгөө нь дараах зүйлийг агуулсан баримт бичиг байна. Үүнд:

- Зөвшөөрлийн хугацаанд хэрэгжүүлэхээр санал болгох үр дүн;
- Дээрх (а) хэсэгт дурдсан үр дүнд хүрэх стратеги;
- Зөвшөөрлийн хугацаанд эрдэсжилт илрүүлэхийн тулд цуглуулахаар төлөвлөсөн өгөгдөл ба мэдээлэл;
- Зөвшөөрлийн хугацаанд хайгуул хийхэд зарцуулахаар тооцож төлөвлөсөн хүний, техникийн болон санхүүгийн нөөц.

Үр дүнд суурилсан ажлын төлөвлөгөө нь хүрэх үр дүнгийн талаарх танилцуулга болон дараах мэдээллийг агуулсан хангалттай нарийвчилсан үндэслэл бүхий баримт бичиг шаардана.

- Эхний ээлжинд (жишээ нь эхний хоёр жилд) санал болгож үйл ажиллагаа, хайгуулын арга техникийн танилцуулга, байршил, хугацаа, хайгуулын үр дүнгээс хамаарч үлдсэн хугацаанд хийх ажлын төлөвлөгөө.
- Өгөгдөл цуглуулах болон хийх геохимийн шинжилгээний тухай мэдээлэл; жишээлбэл, гаргаж авах дээж, өрөмдлөгийн цооногийн дээжийн шинжилгээ, геохимийн ба геофизикийн үр дүн.

Шийдвэр гаргагч нь ажлын төлөвлөгөө батлагдаагүй тохиолдолд ХЗ олгохгүй, хэрэв шийдвэр гаргагч ажлын төлөвлөгөөг батлах боломжгүй бол өргөдлийг буцааж болно.

Санхүүгийн болон техникийн чадвархи

Хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хангалттай санхүүжүүлэх ба зохих нөөцөөр хангуулахын тулд лиценз эзэмшигчийн санхүүгийн болон техникийн чадавхийг ойлгох шаардлагатай. Өргөдөл гаргагч нь ХЗ-ийн нөхцөл болзолыг хэрхэн хангахыг, санхүүгийн болон техникийн чадавхиа нотлон харуулах үүрэгтэй. Санхүүжилт болон техникийн нөөцийг олон эзэмшигч дундаа, эсвэл нэг эзэмшигч нь бусдын өмнөөс хариуцаж болно.

Эдгээр шаардлагыг хангахын тулд өргөдөл гаргагч нь санхүүгийн болон техникийн чадавхи, үүрэг амлалтын талаарх баримт бичигийг зохих нотолгооны хамт ирүүлэх шаардлагатай.

Санхүүгийн болон техникийн чадавхийн нотолгоонд тавигдах шаардлага

Хэрэв ХЗ -ийн санхүүгийн болон техникийн үүрэг хүлээсэн өргөдөл гаргагч нь Күинсланд мужид таван жилээс дээш хугацаанд ХЗ эзэмшсэн түүхтэй бол энэ түүхийн танилцуулгыг өргөдлийн хамт нотолгоо болгон ашиглаж болно.

Хэрэв ХЗ -ийн санхүүгийн болон техникийн үүрэг хүлээсэн өргөдөл гаргагч нь Күинсланд мужид таван жилээс дээш хугацаанд ХЗ эзэмшсэн түүхгүй бол, эсхүл өнгөрсөн түүхээ эш таттхыг хүсэхгүй байгаа тохиолдолд үүрэг амлалтаа биелүүлэх чадвархитай гэдгээ батлах нэмэлт нотолгоог хавсаргах ёстой.

Хэрэв өргөдөл гаргагч нь техникийн ажлыг хөндлөнгийн гэрээт гүйцэтгэгчээр хийлгэх төлөвлөгөөтэй бол ямар ажил үйлчилгээ үзүүлэх гэж буй гэрээт гүйцэтгэгчийн танилцуулгыг шаардлагатай.

Түүх	Санхүүгийн баримт бичиг	Техникийн баримт бичиг
Таван жилээс дээш	Санхүүгийн чадавхийн танилцуулга Санхүүгийн үүрэг амлалтын баримт бичиг	Техникийн чадавхийн танилцуулга Техникийн үүрэг амлалтын баримт бичиг Гуравдагч талын танилцуулга (хэрэв хамааралтай бол)
Таван жил хүртэл	Санхүүгийн чадавхийн танилцуулга Санхүүгийн үүрэг амлалтын баримт бичиг Санхүүгийн чадавхийг нотлох баримт	Техникийн чадавхийн танилцуулга Техникийн үүрэг амлалтын баримт бичиг Гуравдагч талын мэдэгдэл (хэрэв хамааралтай бол) Техникийн чадавхийг нотлох баримт бичиг

Байгаль орчны зохицуулалт

Хайгуул, олборлолтын үйл ажиллагааны байгаль орчны тусгай зөвшөөрлийг *1994 оны Байгаль орчныг хамгаалах тухай хууль* (Байгаль орчны тухай хууль), *2019 оны Байгаль орчныг хамгаалах журмын* дагуу зохицуулдаг. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, журмыг Байгаль орчин, шинжлэх ухааны яам удирддаг.

Байгаль орчны зөвшөөрөл, "байгаль орчны эрх" (ЕА) авах өргөдлийг эрдэс баялгийн хуулийн дагуу ХЗ авах өргөдөлтэй хамт гаргадаг. Хайгуулын үйл ажиллагаанд зориулж Байгаль орчны стандарт зөвшөөрөл авах нэг үйл явцтай. Эрсдэлийн түвшингээс хамаарч Байгаль орчны зөвшөөрөл авах өргөдөл нь стандарт, "сонголтот" эсвэл талбайн онцлогт тааруулсан байж болох бөгөөд сүүлийн хоёр нь ихэвчлэн ашигт малтмал илрүүлэхийн тулд талбайг их хэмжээгээр эвдэх өрөмдлөг хийж талбайг их хэмжээгээр эвддэг ахисан түвшиний хайгуул, эсвэл байгаль орчны хувьд эмзэг талбайд хэрэглэнэ.

Газарт нэвтрэх

Хайгуулын үйл ажиллагаа явуулах зорилгоор газарт нэвтрэх эрхийг нөхөн олговор ба харицан тохиролцсон нөхцөл болон 2014 оны Ашигт малтмал, эрчим хүчний баялгийн тухай (нийтлэг заалтууд) хууль (MERCPA) –р зохицуулдаг. MERCPA нь 10 -аас доошгүй ажлын өдрийн өмнө "нэвтрэх тухай мэдэгдэл"-ийг газар өмчлөгч, эзэмшигчид хүргүүлээгүй бол хувийн эзэмшлийн газарт нэвтрэхийг хориглоно. Нэвтрэх тухай мэдэгдэлд тавигдах шаардлагыг MERCSP журамд заасан болно.

Нэвтрэх тухай мэдэгдэл нь газар эзэмшигчийн газрыг ашиглах үйл ажиллагаанд төдийлөн нөлөөлөхгүй эсвэл ямар ч нөлөөгүй "урьдчилсан үйл ажиллагаа" -нд шаардагдана. Гэсэн хэдий ч, "ахисан түвшний хайгуул" (урьдчилсан үйл ажиллагаанд хамаарахгүй) явуулахын тулд зөвшөөрөл эзэмшигч эхлээд "шаардлага ба нөхөн төлбөрийн гэрээ" (ССА) байгуулах ёстой.

2016 оны Газарт нэвтрэх Кодекс (Хавсралт 4)-д компанийн заавал биелүүлэх ёстой шаардлага болон хамгийн сайн урьдчлан харсан зааврыг тусгасан болно.

Газрын шүүх

MERCPA -заасан дагуу Газрын шүүх нь хувийн эзэмшлийн газарт нэвтрэхтэй холбоотой өргөн хүрээтэй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй. Хэрэв талууд шаардлага ба нөхөн төлбөрийн гэрээ, мөн хойшлуулах эсвэл татгалзах гэрээ байгуулаагүй бол газар эзэмшигч эсвэл хайгуул хийх этгээдийн аль аль нь хайгуул хийх этгээдийн нөхөн төлбөрийн үүргийг

тогтоолгохын тулд Газрын шүүхэд хандаж болно.

Сонгон шалгаруулах үйл явц

Сонгон шалгаруулалтыг газрын тос, байгалийн хий, нүүрс, тохиромжтой тохиолдолд ашигт малтмалын хайгуулд хэрэглэнэ (ашигт малтмалын зөвшөөрөлд ихэнхдээ түрүүлж ирсэнд нь түрүүлж үйлчлэх зарчим үйлчилнэ).

Сонгон шалгаруулалтын өргөдөлийн үнэлгээ ялагчийг сонгох хатуу журам үйлчилдэг. Сонгон шалгаруулах үйл явц ба шалгуурыг сонгон шалгаруулалт зарлах баримт бичигт тусгасан байдаг үүнд ихэвчлэн өргөдөл гаргагчийн санхүүгийн болон техникийн чадавхи ба олон нийттэй харилцах стратегийг анхаарч үздэг. Зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын ялагч нь сонгоны шалгуур *болон* өргөдөл гаргахад (түрүүлж ирсэнд нь түрүүлж үйлчлэх зарчим) тавигдах бүх шаардлагыг (жишээлбэл, байгаль орчин, газар нэвтрэх, нөхөн олговор гэх мэт) хангасан байх ёстой.


Сонгон шалгаруулалтын үйл явц нь тусгай шалгуур, болзол нөхцлийг хэрэглэн өргөн хүрээний бодлогын асуудал, үр дүнг хангадаг бөгөөд сонгон шалгаруулалт зарлахын өмнө засгийн газрын зүгээс бүрэн хэмжээний төлөвлөлт ба зохицуулалтыг шаарддаг, үүнд Күинсландын геологийн (GSQ) албанаас бэлтгэдэг гео шинжлэх ухааны урьдач өгөгдөл мэдээллийн багц мөн багтана.

Улсын хувьд хамгийн сайн үр дүнг хангахын тулд сонгон шалгаруулалтын өргөдөлийг үнэлэхдээ дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- Күинсланд дахь ашигт малтмал талаарх мэдээллийг сайжруулах
- "Ногоон талбайн" ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэх боломжийг хангах, нэмэгдүүлэх
- Газрын гүний эрсдэл өндөртэй хайгуулийг дэмжих ба урамшуулах
- Нэн тэргүүний хэрэгцээтэй эсвэл стратегийн ашигт малтмалын олборлолтыг дэмжих
- Сонгон шалгаруулалт нь хуульчлагдсан үйл явц бөгөөд засгийн газрын хэвлэлээр зарладаг. Сонгон шалгаруулалтанд оролцогч нь сонгон шалгаруулалтын материалыг батлагдсан маягтын дагуу (Маягтын жишээг Хавсралт 5 -аас үзнэ үү) ирүүлэх бөгөөд түүнд бүх шалгуурыг авч үзэхээс гадна сайдад техникийн ба санхүүгийн чадавхийн нотолгоог гаргана.
- Сонгоны талбай нь хэтийн төлөв сайтай газарт байгаа бол үнийн санал болгох хэсгийг нэмж оруулж болно.
- Сонгон шалгаруулалтын хүрээнд ирүүлсэн ажлын төлөвлөгөө нь ихэвчлэн үйл ажиллагаанд суурилсан байна. Энэ төрлийн ажлын төлөвлөгөө нь сонгонд оролцогчийн ХЗ-ийн эхэн үед хийхээр төлөвлөсөн тодорхой үйл ажиллагаануудыг багтаасан байна. Сонгон шалгаруулалтанд ялсан оролцогч нь эдгээр үйл ажиллагааг ХЗ -ийн эхэн үед өөрчлөхгүйгээр хэрэгжүүлэх ёстой.

Сонирхогч талуудын оролцоо

Сонгон шалгаруулалт зарлахаас өмнө шууд нөлөөнд өртөж болзошгүй оролцогч талууд (газар эзэмшигчид, нутгийн уугуул иргэд, орон нутгийн засаг захиргаа гэх мэт) хайгуул хийх талбайн талаар мэдээлж тэдгээрийн оролцоог хангана. Энэхүү мэдээлэл нь сонирхогч талуудад хайгуулын зөвшөөрөл олгох үйл явц, газарт нэвтрэх хэлэлцээрт оролцоход илүү сайн бэлтгэлтэй байх боломжийг олгодог.



Зураг 10. Тендерийн үйл явц

Лицензийн болзол нөхцөл ба түүний нийцэл

Талбайг буцаах

Хайгуулын зөвшөөрөл эзэмшигч нь (хэрэв Сайдын зүгээс өөрөөр шийдвэрлээгүй бол) зөвшөөрлийн талбайн 50% -ийг нь таван жилийн эхний хугацаа дуусахад, зөвшөөрлийн хугацааг сунгасан тохиолдолд үлдсэн талбайн 50% -ийг 10 жилийн дараа (өөрөөр хэлбэл хоёр дахь таван жилийн хугацааны төгсгөлд) заавал буцаах ёстой. ХЗ-ийг дээд тал нь 15 жилийн хугацаагаар олгох боломжтой бөгөөд зөвхөн онцгой тохиолдолд хамгийн сүүлчийн удаа 3 хүртэл жилээр сунгаж болно.

Газарт нэвтрэх

Нэгэнт зөвшөөрөл олгогдсон бол зөвшөөрөлийн талбай багтаж байгаа газрын эзэн, эзэмшигчийн тухайн талбайд хамаарах эрхийг үл харгалзан зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг (ХЗ, БОЗ-ийнболзол нөхцлөөр тодорхойлсон) явуулах эрхтэй. Гэхдээ, ХЗ эзэмшигч нь шаардлага ба нөхөн төлбөрийн гэрээ (ССА), " татгалзах " гэрээ байгуулсан эсвэл түдгэлзүүлэх нөхцөлтэйгээс бусад тохиолдолд зөвшөөрлийн газарт нэвтрэхээс өмнө " нэвтрэх мэдэгдэл" гаргах ёстой.

Зөвшөөрлийн төлбөр хураамж

ХЗ эзэмшигч нь зөвшөөрлийн хураамжийг жилээр төлөх ёстой бөгөөд дэд блокуудын тоог журамд заасан үнийн дүнгээр үржүүлэх замаар хураамжийг тооцдог (2020-21 онд нэг дэд блок тутамд 164.90 ам.доллар байна). Жилийн хураамж төлөх эцсийн хугацаа нь зөвшөөрөл олгосон өдрөөр байна.

Техникийн тайлан

Эрдэс баялгийн тухай хууль нь журамд заасан маягтийн дагуу жил бүр геологийн мэдээллийг агуулсан тайлан гаргах болзол нөхцөл тогтоодог. Тайланг цаасан хэлбэрээр ирүүлнэ гэж тусгайлан заагаагүй бол GSQ Lodgement Portal²⁰ системээр цахим хэлбэрээр өгөх ёстой.

Энэхүү журамд зөвшөөрөл эзэмшигчийн тайлагнах үүргийн биелэлтийг хангуулахын тулд

²⁰ <https://www.business.qld.gov.au/industries/mining-energy-water/resources/minerals-nyyyc/online-services/gsq-lodgement-portal>

тайлан тус бүрт тусгах ёстой мэдээллийг тодорхой заасан. Дараах тайланг үнэн зөв ирүүлэх ёстой. Үүнд:

Үйл ажиллагааны тайланг зөвшөөрөл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жилийн дараах нэг сарын дараа өгнө. Үүнд дараах мэдээллийг оруулсан байх шаардлагатай:

- Зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны техникийн бүрэн тойм.
- Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн танилцуулга.
- Дараагийн тайлант хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа.
- Илрүүлсэн нөөцийн хөндлөн огтлолын зураг.
- Илрүүлсэн томоохон эрдэсжилтийн тодорхойлолт, холбогдох геологийн болон тогтоцын мэдээлэл.
- Геофизикийн болон геохимийн үр дүн

Талбай буцаалтын тайланг зөвшөөрлийн талбайн хэсгийг сайн дурын үндсэн дээр болон зөвшөөрлийн нөхцлийн дагуу буцааснаас хойш хоёр сарын дотор гаргаж өгнө. Тус тайланд буцаагдсан талбайн талаарх ерөнхий мэдээллийг тусгахаас гадна тухайн талбайгаас ашигт малтмал илрүүлэх боломжийн талаар оруулна.

Эцсийн тайланг зөвшөөрлийн хугацаа дууссан эсвэл сайн дураараа буцааж өгсөнөөс хойш хоёр сарын дотор зөвшөөрлийн бүх хугацаанд хийсэн хайгуулын ажлын үр дүнг нэгтгэн ирүүлэх ёстой. Тайланд оруулах мэдээлэл нь аливаа үйл ажиллагааны тайланд оруулах шаардлагатай мэдээлэлтэй ижил байна.

Зардал

Үйл ажиллагааны тайланд зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа ба төсөвлөсөн зардалын задаргаа бүхий зардалын танилцуулгыг тусад нь гаргаж оруулах ёстой. Журамд ямар мэдээлэл тайланд оруулах, ямар зардалыг хайгуулын зардалд тооцогдохгүй талаар тодорхой заасан байдаг.

Баруун Австралиас ялгаатай нь жилд зарцуулах зардлын доод хэмжээг журамд заагаагүй бөгөөд энэ нь үйл ажиллагаа, үр дүнд суурилсан эсэхийг үл харгалзан өргөдөл гаргагчийн санал болгосон төлөвлөгөөнөөс хамаардаг бөгөөд жилийн зардал нь тухайн жилд хийх ёстой үйл ажиллагаатай дүйцэх ёстой (жишээлбэл, техникийн суурин судалгаа эсвэл өрөмдлөг гэх мэт).

Үйл ажиллагааны тайланд тусад нь гаргаж оруулсан зардлын тайлан нь батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу хийгдсэн үйл ажиллагаа тус бүрийн зардлыг тусгасан байх ёстой²¹.

Болзол нөхцлийн өөрчлөлт

ХЗ эзэмшигч нь Эрдэс баялгийн тухай хуульд заасан зөвшөөрлийн бүх болзол нөхцлийг биелүүлж, батлагдсан ажлын төлөвлөгөөний үйл ажиллагааг Эрдэс баялгийн тухайн хуулийн 141 (1) (а) хэсэгт заасан “боломжтой хэр хэмжээ” гэдэг ойлголтын түвшинд хэрэгжүүлэх эсвэл үр дүнг ханган ажиллах ёстой.

Үр дүнд суурилсан ажлын төлөвлөгөө нь зөвшөөрөл эзэмшигч Яамнаас зөвшөөрөл авахгүйгээр

²¹ https://www.resources.qld.gov.au/data/assets/pdf_file/0009/1337688/ep-expenditure-statement-template.pdf

хайгуулын ажлын үр дүнд нийцүүлэн үйл ажиллагаа өөрчлөх боломжтой. Үр дүнд суурилсан батлагдсан ажлын төлөвлөгөөний болзол нөхцөлийг өөрчлөхийн тулд ХЗ эзэмшигч хүсэлт гаргах шаардлагагүй.

Үйл ажиллагаанд суурилсан ажлын төлөвлөгөөний болзол нөхцлийг өөрчлөхийн тулд хүсэлт гаргах шаардлагатай бөгөөд зөвшөөрөл эзэмшигч төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатайг мэдсэн даруй хүсэлт гаргах ёстой.

Өргөдөл²² гаргахдаа дараах мэдээлэл бүхий баримт бичгийг хавсаргасан байна. Үүнд:

- Болзол нөхцөлийн хүсэж буй өөрчлөлт (тухайлбал, хугацаа, үүрэг амлалт, түүнд оруулах нэмэлт өөрчлөлт).
- Хийсэн ажил, эсвэл хүрсэн үр дүн.
- Онцгой нөхцөл байдлын улмаас оруулах шаардлагатай өөрчлөлт эсвэл онцгой нөхцөл байдлын тайлбар.
- Болзол нөхцөлийг биелүүлэхийг оролдсон байдал.
- Шинэ үндэслэлийг дэмжих техникийн болон хүний нөөцийн аливаа өөрчлөлт

Үл нийцэлд ногдуулах хариуцлага

- Хэрэв Сайд ХЗ эзэмшигч нь ХЗ -ийг олгосон зорилгод нийцэхгүй үйл ажиллагаа явуулсан, зөвшөөрлийн төлбөрийг төлөөгүй, аливаа болзол нөхцөлийг биелүүлээгүй гэж үзвэл хариуцлага ногдуулж болно. Нөхцөл байдлаас хамааран зөвшөөрлийг цуцлах эсвэл торгууль ногдуулах зэрэг хариуцлага тооцох боломжтой.
- Сайд зөвшөөрлийг цуцлах эсвэл торгууль ногдуулах тухай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр мэдэгдэл хүргүүлж зөвшөөрөл эзэмшигчийн тайлбар авахаас өмнө зөвшөөрөл цуцлах эсвэл торгох хариуцлага хүлээлгэхгүй.

²² https://www.resources.qld.gov.au/data/assets/pdf_file/0008/259856/application-vary-conditions.pdf

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Нэр томъёо	Тодорхойлолт
Хүрэн талбайн хайгуулын ажил	Ашигт малтмал олборлож байгаа газарт хайгуул хийхэд хамаарна. Уул уурхайн компаниуд өөрсдийн ашиглалтын талбайн зэргэлдээ мэдэгдэж буй ашигт малтмалын тоо хэмжээ ба чанарыг тодорхойлох эсвэл ойролцоо байршилтай шинэ ордыг хайж олохын тулд ихэвчлэн хийдэг.
Үндсэн хууль	1901 оны 1 -р сарын 1 -нд Австралийн зургаан колони нь Австралийн зургаан муж улс болж Австралийн холбооны улс болсон. Үндсэн хууль нь холбооны засгийн газрын тогтолцоог байгуулж, үндэсний засгийн газар болон зургаан мужийн хооронд эрх мэдлийн хуваарилалтыг тогтоосон. Австралийн Үндсэн хууль нь цөөн асуудлаас бусад тохиолдолд муж улсуудын хууль гаргах асуудлыг хязгаарладаггүй бөгөөд муж бүр өөрийн гэсэн үндсэн хуультай. Муж бүр болон Хойд Нутаг өөрийн гэсэн Ашигт малтмалын тухай хуультай.
Бүрхүүл	Австралийн газар нутгийн дөрөвний гурвыг бүрхсэн эрдэсжилтийн дараах тунамалын сав газар.
Эзэнт	Үндсэндээ Засгийн газар, Австралийн эсхүл мужийн Засгийн газар.
Эзэнт улсын газар	Эзэнт улсын буюу Улсын газар гэдэг нь хувь хүн, компанид биш Засгийн газрын мэдэлд байдаг газар юм. Үүнд нөөцийн газар (хамгаалалтын талбай, ойн сан гэх мэт) орох бөгөөд мужийн засгийн газрын холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг.
Цуцлах	Эрх, зөвшөөрлийн болзол нөхцөлийг хангаагүйгээн улмаас түүнийг хүчингүй болгохыг хэлнэ. Энэ нэр томъёог <i>1978 оны Уурхайн тухай хуульд</i> (Баруун Австрали) албан ёсоор ашигласан.
Ногоон талбайн хайгуул	Ногоон талбайн хайгуул нь судлагдаагүй эсвэл бүрэн судлагдаагүй газарт явагддаг бөгөөд ашигт малтмалын шинэ ордыг илрүүлэхэд чиглэгддэг. Энэ төрлийн хайгуул нь өндөр эрсдэлтэй бөгөөд орд илрүүлсэн тохиолдолд ихээхэн ашигтай байх магадлалтай. Энэ хандлага нь томоохон орд илрүүлж арилжаалах эсвэл хамтарсан компани байгуулах зорилготой жижиг компаниуд илүү сонирхдог.
Улсын нийт бүтээгдэхүүн /УНБ/	УНБ нь олон улсын болон муж улс хоорондын цэвэр худалдааг оруулж тооцсон муж улсын бараа, үйлчилгээний нийт эдийн засгийн үйлдвэрлэл юм. Улсын хэмжээнд дүйцэх нэр томъёо нь Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) юм.
Жижиг компаниуд	Хайгуулын үйл ажиллагаагаа санхүүжүүлэх орлогын урсгал хязгаарлагдмал (эсвэл огт байхгүй) компаниудыг хэлнэ. Хайгуулын үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрөнгөөр голдуу санхүүжүүлнэ.
Хуулийн харьяалал	Хууль ёсны шийдвэр ба тогтоол гаргах албан ёсны эрх мэдэл (үйл үг). Хууль тогтоомж хэрэгжих нутаг дэвсгэр (нэр үг).
Түрээс	(1) "Эрх, зөвшөөрөл" гэдгийг үзнэ үү. (2) Нэг тал нь (тухайлбал, Засгийн газар) үл хөдлөх хөрөнгийг тодорхой болзол нөхцөлтэйгээр тодорхой хугацаанд, өмчлөх эрхээ хадгалан үнэ цэнэтэй зүйлээр солилцож нөгөө талд (тухайлбал, уул уурхайн компанид) шилжүүлэх тохиролцсон гэрээ. Түрээс нь лиценз биш юм.
Лиценз	(1) "Эрх, зөвшөөрөл" гэдгийг үзнэ үү. (2) Эрх бүхий байгууллагаас (тухайлбал, Засгийн газар) тодорхой эрх хэрэгжүүлэхээр (жишээлбэл, хайгуулын үйл ажиллагаа явуулах) олгосон зөвшөөрөл (гэрчилгээ эсвэл баримт бичиг ашиглан) олгосон (гэрчилгээ эсвэл баримт бичиг хэлбэрээр), зөвшөөрөл олгоогүй тохиолдолд хууль бус үйл ажиллагаа (хууль бусаар нэвтрэх) болох тодорхой давуу эрх (жишээлбэл, хайгуулын үйл ажиллагаа явуулах).
Эрдэс/ ашигт	Байгалийн гаралтай, ихэвчлэн органик бус бодисууд, гэвч эдгээр бодисуудаас үүссэн

малтмал	чулуулаг болон нүүрс зэрэг байгалын гаралтай органик бүтээгдэхүүн мөн багтаж болно.
Уул уурхайн хууль тогтоомж	Улсын хэмжээнд мөрдөх хууль, журам ба бодлогын багц.
MMOL	MyMinesOnline Күинсландын ашигт малтмалын эрх, зөвшөөрөл авах өргөдөл хүлээж авах ба шийдвэрлэх вебсайт
МТО	Mineral Titles Online нь Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын эрх зөвшөөрөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл бүхий, эрх зөвшөөрөл эзэмшигчид өөрсдөө онлайнгаар эрх зөвшөөрөлөө удирдах боломжтой Баруун Австралийн Засгийн газрын вэб сайт юм.
Зөвшөөрөл	(1) "Эрх, зөвшөөрөл" гэдгийг үзнэ үү. (2) Эрх бүхий байгууллагаас хувь хүн, аж ахуйн нэгжид тодорхой үйл ажиллагаа (жишээлбэл, хайгуулын үйл ажиллагаа) явуулахыг зөвшөөрч олгосон лиценз эсвэл бусад баримт бичиг. Зөвшөөрлийн зорилго нь хууль тогтоомж мөрдөж ажиллахыг баталгаажуулах явдал бөгөөд төсвийн орлогын эх үүсвэр болдог.
Бодлого	Зорилгын илэрхийлэл, үүнийг шийдвэр гаргахад чиглүүлэх, хууль болон журам хэрэгжүүлэхэд туслах зорилгоор засгийн газрын байгууллагаас дүрэм болон тэмдэглэл байдлаар хэрэгжүүлдэг.
Эрэлчин	Өөрийн зардлаар хайгуулын ажлаа санхүүжүүлдэг хувь хүмүүс (ихэвчлэн геологийн албан ёсны ур чадваргүй). Эдгээр нь ихэвчлэн Австралийн уул уурхайн түүхийн эхэн үед илрүүлсэн ордуудад хамаарна.
Журам	Хууль хэрэгжүүлэхийн тулд хуульчлан тогтоосон дүрэм.
Хууль	Хайгуул, ашиглалт зэрэг тодорхой асуудалтай холбоотой харилцааг зохицуулахаар хууль тогтоох байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичиг.
Эрх, зөвшөрөл	Түрээс, лиценз, эрх, зөвшөөрөл, эрх мэдэл болон эзэмшлийн бусад бүх төрлийн эрхэд хамаарах хамтатгасан нэр томъёо.
Эзэмшлийн эрх	
Эрх	

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ 1	Маягт 5 Үйл ажиллагааны тайлан
ХАВСРАЛТ 2	Баруун Австралийн яамны өргөдлийн дотоод хяналтын жагсаалт
ХАВСРАЛТ 3	Күинсландын хайгуулын зөвшөөрөл авах өргөдлийн маягт
ХАВСРАЛТ 4	Газарт нэвтрэх код
ХАВСРАЛТ 5	Күинсландын нүүрсний төндөрийн маягт

Хавсралт 1 – Маягт 5 Үйл ажиллагааны тайлан

Хавсралт 2 – Баруун Австралийн яамны өргөдлийн дотоод хяналтын жагсаалт

Хавсралт 3 –Күинсландын хайгуулын зөвшөөрөл авах өргөдлийн маягт

Хавсралт 4 – Газарт нэвтрэх код

Хавсралт 5 –Құинслаңдын нүүрсний теңдерийн маягт